

"ЖЕНДЭР БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН" ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН - 2021

Монгол Улс



NATIONAL
STATISTICS OFFICE
OF MONGOLIA



ТАЛАРХАЛ

Жендэр ба хүрээлэн буй орчин – Монгол улс 2021 туршилт судалгааг Монгол улсын Үндэсний Статистикийн Хорооны дарга А.Ариунзаяа болон Б.Батдаваа нарын удирдлаган доор амжилттай хэрэгжүүллээ. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалтын үйл ажиллагаа, арга хэмжээ бүрийг А.Амарбал, Д.Даваажаргал нар удирдан гүйцэтгэв. Нийт 6 багийн ахлагч, 30 тоологчтой баг судалгааг гардан гүйцэтгэж, Сара Валерогийн удирдлаган доор НҮБ-ын Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллага судалгааны үзэл баримтлалыг боловсруулж, удирдамж болон холбогдох бусад материалыг Монгол улсын ҮСХ-той хамтран гүйцэтгэснээс гадна хамтран санхүүжүүлэв. Мөн НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын зүгээс санаачлан хэрэгжүүлж буй жендэрийн статистик мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг дэмжих санаачлагын хүрээнд тус судалгаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн болно. Д.Даваажаргал, Сара Дуэрто Валеро, Шеха Каул, Цз Юу Чан нар энэхүү тайланг хамтран бичив. Мари Энн Пэркинс тайланг хянан нягталж, Blossom.it тайлангийн загварыг боловсрууллаа.

Монгол улсын ҮСХ болон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага Австрали, Франц, Ирланд, Итали, Швед улсын засгийн газар, Билл ба Мелинда Гэйтс сангийн "Охид эмэгтэйчүүд бүрийг үнэлдэг болгох" хөтөлбөрийн зүгээс үзүүлсэн дэмжлэгт гүнээ талархаж байгаагийн зэрэгцээ тус судалгаанд цаг гарган идэвхтэй оролцсон Монгол улсын эмэгтэй, эрэгтэй иргэн бүрт талархал илэрхийлье.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	6
Танилцуулга	7
Судалгааны зорилго ба хамрах хүрээ	7
Газар зүйн байршлийн хамрах хүрээ	8
Хамаарах хугацаа	8
Түүврийн процедур	9
Түүврийн хүрээ	9
Судалгааны талбар дахь ажиллагаа	10
Мэдээлэл боловсруулалт	10
Өрхийн ерөнхий шинж байдал	10
Үр дүн	12
I бүлэг. Гамшигт өртөх байдал, бэлэн байдал, үр дүн	12
Ii бүлэг. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөх байдал ба түүний сөрөг нөлөөг даван туулах стратеги	21
Iii бүлэг. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын алдагдал, хүрээлэн буй орчин ба аж байдал	27
Iv. бүлэг. Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны доройтол, шийдвэр гаргалт	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Амьжиргааны болон орлого олох зорилгоор хүрээлэн буй орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг хүн амын тоо, хүйсээр (хувь)	11
Зураг 2.	Хүрээлэн буй орчны эрсдэл өндөртэй байршил, газар нутагт амьдардаг хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйс болон байршлаар, (хувь)	12
Зураг 3.	Сүүлийн 12 сарын хугацаанд нэг буюу хэд хэдэн удаагийн гамшигт үзэгдэл, түүнтэй холбоотой аюулд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	13
Зураг 4	Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртөж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл ахуйн бүтээгдэхүүн авахад хүндрэлтэй тулгарсан хүн амын эзлэх хувь, хүйс, байршлаар (хувь)	14
Зураг 5.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртсөн, үүний улмаас сэтгэцийн эрүүл мэнд нь хохирсон хүн амын эзлэх хувь, хүйсээр	14
Зураг 6.	Сүүлийн 12 сарын хугацаанд гамшигт үзэгдэл, аюулд өртсөн, амьжиргаа нь сүйдэж, хор хөнөөл амссан хүн амын эзлэх хувь, хүйс, амьжиргааны төрлөөр (хувь)	15
Зураг 7.	Газар тариалан, мал аж ахуй нь гамшигт өртсөн, хор хөнөөл амссан иргэдийн хүн амд эзлэх хувь, хүйсээр, орлогын гол эх үүсвэр байсан эсэх (хувь)	16
Зураг 8.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртсөн, үүний улмаас түр болон байнгын нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр, нүүлгэн шилжүүлэлтийн төрлөөр (хувь)	16
Зураг 9.	Сүүлийн 12 сарын хугацаанд гамшиг, аюулт үзэгдэлд өртсөний улмаас цалин, хөлсгүй гэрийн ажил, асаргаанд зарцуулсан цагийн нэмэгдэл, хүйсээр, цалин хөлсгүй гэрийн ажлын төрлөөр (хувь)	17
Зураг 10.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртөж, орон байр нь эвдэрсэн, сүйрсэн хүн амын эзлэх хувь, хүйс болон хохирлын түвшингээр (хувь)	18
Зураг 11.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртөж, нийтийн тээврээр зорчих боломжгүй болсон хүн амын эзлэх хувь, хүйс болон байршлаар (хувь)	18
Зураг 12.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртсөн хүн амын гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдлын эзлэх хувь, хүйсээр, гамшигт үзэгдлийн төрлөөр (хувиар)	19
Зураг 13.	Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртсөн хүн амаас гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан иргэдийн эзлэх хувь, хүйсээр, арга хэмжээний төрлөөр (хувиар)	20
Зураг 14.	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 5 жилд орлого болон бусад эх үүсвэрийн хэмжээ нь буурсан хүн амын эзлэх хувь, хүйсээр болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөний төрлөөр (хувь)	22
Зураг 15.	Цаг агаар огцом хүйтрэх, түүний нөлөө, үр дагаврын талаарх мэдээллийг олон төрлийн сувгаар авсан иргэдийн эзлэх хувь, хүйсээр, мэдээллийн эх сурвалжаар (хувь)	23
Зураг 16.	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүнсний хэрэглээ нь буурсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	24
Зураг 17.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эрүүл мэндийн өвчлөл нэмэгдсэн гэж үзсэн хүн амын эзлэх хувь, хүйс, төрлөөр (хувь)	25
Зураг 18.	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүүхэд, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах болон гэрийн ажилд зарцуулсан цаг хугацаа нь нэмэгдсэн хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	25
Зураг 19.	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ажлын байраа алдаж, ургац буурсан, ургац нэмэгдүүлэх антибиотик их хэмжээгээр хэрэглэсэн хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	26
Зураг 20.	Орлогын гол эх үүсвэр нь байгаль орчинтой холбоотой хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	27
Зураг 21.	Орлогын эх үүсвэр нь байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйс, эрхэлж буй үйл ажиллагааны төрлөөр (хувь)	28
Зураг 22.	Байгаль орчинтой холбоотой ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрлөөр (хувь)	30
Зураг 23.	Байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлж амьжиргаагаа залгуулдаг хүн амын эзлэх хувь, хүйсээр, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэрээр (хувь)	31
Зураг 24.	Сүүлийн 12 сарын хугацаанд байгаль орчинд түшиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн тус үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдсэн байдал, хүйсээр, (хувь)	32

Зураг 25.	Амьжиргааны зорилгоор зэрлэг ой, бэлчээр, ойн бүсээс малын тэжээл, мод бэлтгэх, ан агнуур хийх, малаа бэлчээж буй хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	33
Зураг 26.	Хөдөө аж ахуйн зорилгоор эзэмшиж, ашиглаж буй газар нь хөрсний доройтолд орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр, хөрсний доройтлын төрлөөр (хувь)	34
Зураг 27.	ХАА-н зорилгоор эзэмшиж, ашиглаж буй газар нь хөрсний доройтолд орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	35
Зураг 28.	ХАА-н зорилгоор ашиглаж, эзэмшиж буй газартаа бордоо ашигласнаас үүдэн гарах эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	36
Зураг 29.	ХАА-н зорилгоор ашиглаж, эзэмшиж буй газартаа ХАА-н газар, малын бэлчээрт үзүүлж буй сөрөг нөлөө, гарах эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	36
Зураг 30.	Дангаар болон хамтран эзэмшдэг малаа ихэвчлэн малладаг хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	37
Зураг 31.	Байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалж буй мал аж ахуй эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)	38
Зураг 32.	Мал, амьтны аж ахуй эрхлэх арга дадал нь байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн хүн амын эзлэх хувь, арга, дадлын төрөл, хүйсээр (хувь)	38
Зураг 33.	Охид, эмэгтэйчүүд, эсвэл эрэгтэйчүүд, хөвгүүд нь хоолоо хийдэг өрхийн эзлэх хувь, ашиглаж буй түлшний төрлөөр (хувь)	39
Зураг 34.	Өрхийн хэрэглээний мод, түлээгээ бэлтгэх ажил хариуцсан бүлгийн эзлэх хувь, хүйсээр (хувь)	40
Зураг 35.	Өрхийн хэрэглээний ус зөөх ажил хариуцсан бүлгийн эзлэх хувь, усны эх үүсвэр хүртэлх зайгаар (хувь)	41
Зураг 36.	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг арилгах, бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байгууллагад харьяалагддаг хүн амын эзлэх хувь, хүйсээр	41

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Жендэр ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгаанд ашигласан модуль	8
Хүснэгт 2.	Жендэр ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны түүврийн хүрээ	9

ТОВЧИЛСОН ҮГ

САТИ	Утсаар мэдээлэл цуглуулах компьютерт суурилсан арга
КОВИД-19	2019 Коронавирус өвчин
ЖХБОС-Т	Жендэр, хүрээлэн буй орчны туршилт судалгаа
МУҮСХ	Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ГДСЭ	Гэмтлийн дараах стрессийн эмгэг
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүйсийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхижуулах байгууллага

ТАНИЛЦУУЛГА

Жендер ба хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгаа нь Монгол орны эрэгтэй, эмэгтэй хүн ам ба хүрээлэн буй орчны асуудал, хоорондын харилцаа, харилцан хамаарлыг судалсан үндэсний хэмжээний, иж бүрэн, өрхийн судалгаа юм. Энэхүү судалгаа нь өрхийн болон хувь хүний түвшинд байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн урт хугацаанд үзүүлэх үр дагавар, сөрөг нөлөөнд өртөх, түүнийг даван туулах түвшнийг тооцон хэмждэг судалгаа юм. Мөн энэхүү судалгаагаар эрэгтэй, эмэгтэй иргэдийн өдөр тутмын үйл ажиллагаа, аж байдлаар дамжуулан хүрээлэн буй орчинд үзүүлэх харилцан нөлөөллийг үнэлэв.

Жендер ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааг Монгол улсын ҮСХ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын (Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүйсийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах байгууллага) дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгууллаа. Судалгааны агуулгыг гаргахдаа НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагаас гаргасан тухайлбал Жендер ба хүрээлэн буй орчны харилцан хамаарал, уялдаа холбоог хэмжих загвар асуулгын урьдчилсан хувилбар¹ зэрэг олон улсын гарын авлагыг удирдамж болгосноос гадна үндэсний оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр Монгол орны онцлог, нөхцөлд нийцүүлэн холбогдох тохиргоо хийсэн болно. Тус судалгаанаас гарах тооцоолол нь Тогтвортой хөгжил 2030, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндайн үйл ажиллагааны хүрээ, Уур амьсгалын өөрчлөлтийн Дэлхийн мониторинг – статистик, багц үзүүлэлт зэрэг үндэсний болон олон улсын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай хүйсээр ангилсан мэдээллээр хангах юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажил коронавирусын халдварын (COVID-19) цар тахлын үед хийгдсэн тул төлөвлөсөн ёсоор нүүр тулсан ярилцлага г.м арга хэрэгсэл ашиглан мэдээлэл цуглуулах боломж хязгаарлагдмал байв. Иймд судалгааны мэдээллээ төлөвлөж байснаас бага түүврийн хүрээнд багтаан Утсаар мэдээлэл цуглуулах компьютерт суурилсан арга (CATI) ашиглан цуглуулав. Судалгаа явагдсан хугацаанд коронавирусын цар тахлын зэрэгцээ хэд хэдэн байгалийн гамшигт үзэгдэл тухайлбал, 2020, 2021² онд тохиосон зуд, (өвлийн улиралд их хэмжээний цас орох гамшигт үзэгдэл), 2021 оны 3-р сард тохиосон³ хүчтэй элсэн шуурга, мөн оны 7-р сард⁴ тохиосон их хэмжээний, гэнэтийн үер зэрэг олон гамшигт үзэгдэл тохиолдов. Судалгааны үр дүн Монгол улсын нийт хүн ам, тэр дундаа хөдөө орон нутгийн хүн амын гамшигт өртөмтгий байдал, уур амьсгалын өөрчлөлтийн урт хугацаанд үзүүлэх нөлөөлөл, эдгээр нөлөөллийг өдөр тутмын амьдралдаа мэдэрч буй эмэгтэй, эрэгтэй иргэдийн туршлага зэргийг тусгасан болно.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Жендер ба хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны гол зорилго нь Монгол улсад энэ төрлийн судалгаа явуулах боломж, нөхцөлийг турших, дэлхий нийтээр ашиглаж буй судалгааны асуулгыг Монгол орны онцлог, нөхцөл байдал нийцүүлэн тохиргоо хийх, хэд хэдэн сэдэвчилсэн агуулгаар судалгааны урьдчилсан үр дүн гаргах, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах явдал байв. Өрхийн түвшинд мэдээлэл цуглуулахад орон байр, сууцны шинж байдлын мэдээллээс гадна гамшиг, аюулт үзэгдэлд өртөх байдал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, хүрээлэн буй орчны өөрчлөлттэй холбоотой өрхийн хэрэглээ, орлого, хөрөнгийн өмчлөл, ашиглалт, шийдвэр гаргалт, шилжилт хөдөлгөөн зэрэг олон сэдвээр тухайн өрхийн эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хувь хүний туршлага, мэдээллийг цуглуулахад мөн анхаарлаа хандуулдаг. Энэхүү судалгааг зохион байгуулахдаа Жендер болон хүрээлэн буй орчны уялдаа, харилцан хамаарлыг хэмжих загвар асуулга, олон улсын удирдамжийг Монгол орны онцлог, нөхцөлд нийцүүлэн дагаж мөрдсөнөөс гадна хувь хүний болон өрхийн түвшний модуль ашиглан зохион байгуулсан болно.

1 Жендер ба хүрээлэн буй орчны харилцан хамаарал, уялдааг хэмжих загвар асуулга.

2 Дэлгэрэнгүйг <https://reliefweb.int/report/mongolia/acaps-anticipatory-briefing-note-mongolia-anticipated-impact-dzuds-15-january-2021>.

3 Reliefweb (2021), Монгол Улс: Элсэн шуурга – 2021 оны 3-р сар. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://reliefweb.int/disaster/st-2021-000024-mng>.

4 Reliefweb (2021), Монгол улс: Гэнэтийн үер – 2021 оны 7-р сар. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://reliefweb.int/disaster/ff-2021-000098-mng>.

Хүснэгт 1: Жендер ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгаанд ашигласан модуль

МОДУЛЬ	ТАЙЛБАР	ТҮВШИН
0	Өрхийн жагсаалт	Өрх
1	Хувь хүний шинж байдал	Хувь хүн
2	Өрхийн шинж байдал: Барилгын материал, байршил, өмч	Өрх
3	Өрхийн шинж байдал: Ус, ариун цэврийн байгууламж	Өрх
4	Өрхийн шинж байдал: Эрчим хүч	Өрх
5	Хүрээлэн буй орчны холбогдолтой ажил эрхлэлт	Хувь хүн
6	Гамшигт өртөх байдал, бэлэн байдал, үр дүн	Хувь хүн
7	Өмчийн эзэмшил, ашиглалт	Хувь хүн
8	Хүрээлэн буй орчны холбогдолтой орлого, аж байдал	Хувь хүн
9	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөх байдал, бэлэн байдал	Хувь хүн
10	Шийдвэр гаргалт, шилжилт хөдөлгөөн	Хувь хүн

ГАЗАР ЗҮЙН БАЙРШЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Тус судалгааны түүврийн дизайныг боловсруулахдаа гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө хамгийн их байдаг, хамгийн алслагдсан бүс нутгийг аль болох түлхүү хамруулж, газар зүйн онцлог шинжүүдийг төлөөлөх байршлуудыг хамруулахыг зорив. Монгол орны экологийн онцлог, шинж байдал олон янз бөгөөд өмнөд хэсэгт говь, хойд болон баруун талаараа хүйтэн, уулархаг бүс нутагтай. Монгол орны нутаг дэвсгэрийн 40 орчим хувь нь уул толгодоор бүрхэгдсэн бол үлдсэн хэсэг нь тэгш тал байдаг. Ландшафт нь уулын нуруу, тайга, ойт хээр, хээр тал, говь, цөлийн бүс нутгийг хамарсан олон янз байдаг. Урд болон баруун тийш урсдаг голууд ихэвчлэн дотоодын нууруудад нэгдэх эсвэл давстай нууруудтай нийлж төгсдөг⁵. Газар орон бүр өвөрмөц цаг ууртай, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлд орох магадлалтай юм. Тиймээс түүврийн загвар боловсруулахдаа бүх бүс нутаг, 9 дүүрэг, 21 аймгийг төлөөлөх түүврийн загвар гаргахад анхаарав. Харин хот, хөдөө гэсэн ангиллын хувьд Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд ашигладаг ангилал болох хот гэдэгт нийслэл, аймгийн төв, хөдөөд сумын төв болон ойр орчмын хөдөө орон нутгийг хамруулан ойлгодог ангиллыг ашиглав.

Газар зүйн бүс тус бүрд, 18 болон түүнээс дээш настай гишүүнтэй өрх бүрийг ганцаарчилсан ярилцлага хийх боломжтой Жендер ба хүрээлэн буй орчин туршилт судалгааны нэгж гэж үзсэн болно.

ХАМААРАХ ХУГАЦАА

Жендер ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2021 оны 8-р сарын 9-өөс 11-р сарын 6-ны өдрийн хооронд гүйцэтгэв. Судалгааны ихэнх мэдээлэл нь ярилцлага хийсэн өдрөөс хойш 12 сарын хугацааг хамрах боловч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө г.м харьцангуй удаан явцтай үйл явдлын хугацааг 12 сарын хугацаанд үл хамаарах үйл явдал гэдгийг тусгайлан тэмдэглэн оруулсан болно.

5 Монгол улсын тайлан, Ази тивийн гамшигийн эрсдлийг бууруулах төв (ADRC) (2011). Дэлгэрэнгүй мэдээллийг www.adrc.asia/countryreport/MNG/2011/FY2011B_MNG_CR.pdf.

ТҮҮВРИЙН ПРОЦЕДУР

Жендэр ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны түүврийг тодорхойлохдоо гурван шатлалт магадлалт түүврийн аргыг ашигласан бөгөөд нийт 2800 өрх сонгосон болно. Нэгдүгээр шатанд, нийслэл хот, 4 бүсээс (Баруун, Хангай, Төв, Зүүн) 140 тооллогын нэгж нийт өрхийн тоотой пропорциональ хамааралтай сонгогдсон. Хоёрдугаар шатанд, сонгогдсон тооллогын нэгж бүрээс санамсаргүй түүврийн аргаар 20 өрхийг сонгосон бол гурав дахь шатанд өрхийн нэрсийн жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар насанд хүрсэн нэг эмэгтэй, нэг эрэгтэйг (18 ба түүнээс дээш насны) сонгон авч судалгаанд хамрууллаа. Судалгаанд нийт 2062 эмэгтэй, 1752 эрэгтэй хамрагдав.

ТҮҮВРИЙН ХҮРЭЭ

Судалгаанд Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүн болох 897,427 өрхийн жагсаалтад үндэслэсэн түүврийн хүрээг ашигласан бөгөөд газар зүйн ямар нэг бүс нутгийг хасаагүй болно. Түүврийн хүрээн дэх мэдээлэлд тухайн өрхийн байршил, өрхийн тэргүүний нэртэй холбоотой газар зүйн кодыг оруулсан болно.

Түүврийн хүрээ нь тухайн өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг агуулаагүй тул Жендэр ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны ярилцлагын үеэр цуглуулсан өрхийн хүн ам зүйн хүснэгтээс санамсаргүй түүврээр насанд хүрсэн нэг эрэгтэй, нэг эмэгтэйг сонгосон болно. Энэхүү санамсаргүй түүврийн шатнаас өмнө өрхийн жагсаалт дахь гишүүдийн мэдээллийг насанд хүрсэн гишүүд (18 болон түүнээс дээш настай) болон хүйсээр нь ангилан нарийвчилсан болно. Судалгааны түүвэрт нэг эмэгтэйг насанд хүрсэн эмэгтэйчүүдээс, нэг эрэгтэйг насанд хүрсэн эрэгтэйгээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Тодорхой нэг дэд бүлэгт шаардлага хангасан хариулагч сонгогдоогүй тохиолдолд ярилцлага хийгээгүй бөгөөд насанд хүрсэн нэг гишүүнтэй өрх сонгогдсон тохиолдолд хүйс харгалзахгүй ярилцлага хийж мэдээлэл цуглуулав.

Хүснэгт 2: Жендэр ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны түүврийн хүрээ

		2020 ОНЫ ХАОСТ		ЖЕНДЭР БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН 2021 ТУРШИЛТ СУДАЛГАА – МОНГОЛ		
ГАЗАР ЗҮЙН БҮСЧЛЭЛ		ӨРХИЙН ТОО	ТООЛЛОГЫН ТАЛБАЙН ТОО	ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ (ӨРХ)	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭМЭГТЭЙ	СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭРЭГТЭЙ
11	Улаанбаатар (нийслэл)	411,420	169	620	254	344
12	Аймгийн төв	180,307	198	1,139	403	508
22	Сумын төв	110,596	367	828	348	452
32	Хөдөө	195,104	1074	494	196	252
Ямар ч байршил бүртгэгдээгүй					861	196
Монгол улс (нийт)		897,427	1808	3081	1,201	1,556

Түүврийн шатанд гарах магадлалын ялгаатай байдлыг харгалзан үзэх зорилгоор, түүвэрт багтсан бие даасан өрх бүрээр, мөн санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон эрэгтэй, эмэгтэй гишүүн бүрээр түүврийн жинг тооцсон. Энэхүү судалгааны түүврийн жинг хариулт өгөөгүй тохиолдол тус бүрд тохируулан жинлэсэн бөгөөд ХАОС-ны 2020 оны тооллогын үр дүнгээр гарсан бие даасан өрх, иргэдийн тоог бүс нутгаар ангилсан ангиллын дагуу тохиргоо хийсэн болно. (хүснэгт 2)

СУДАЛГААНЫ ТАЛБАР ДАХЬ АЖИЛЛАГАА

Судалгааны мэдээлэл цуглуулах ажиллагааг нүүр тулсан ярилцлагын арга ашиглан гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч коронавирус цар тахлын улмаас мэдээлэл цуглуулах ажилд бэрхшээлүүд тулгарсан юм. Тиймээс судалгааны мэдээллийг урьдчилан бэлтгэгдсэн тоологч, хянагч нарын баг утсаар мэдээлэл цуглуулах компьютерт суурилсан арга (CATI) ашиглан цуглуулсан юм. Тооллогын мэдээллийг хянагч нарыг ҮСХ-ны зүгээс сонгон шалгаруулж ажиллуулсан болно. Мэдээлэл цуглуулах үе шат эхлэхээс өмнө, бүх хянагч, тоологчдыг судалгааны үндсэн концепц, ойлголт, ухагдахуун, судалгааны талбарт явуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам зэргийг дэлгэрэнгүй тайлбарласан сургалтад хамруулсан юм.

Судалгааны асуулгын маягтыг CS-Pro программ ашиглан боловсруулсан бөгөөд ҮСХ-ны зүгээс судалгаа хариуцсан менежер А.Амарбал судалгааны мэдээллийн чанарын баталгаажуулалт, тоологч нарын ажлын чанарт хяналт тавин, удирдан зохион байгуулав.

Судалгааг цар тахлын үед, утсаар мэдээлэл цуглуулах компьютерт суурилсан арга ашиглан цуглуулсан тул Жендер ба Хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны өрхийн судалгаанд хамрагдалтын хувь (бүрэн хариулсан) 47 хувь байлаа. Эдгээр өрхөөс 2062 насанд хүрсэн эмэгтэй, 1752 эрэгтэйг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, судалгаанд хамруулсан бөгөөд нийт судалгаанд хамрагдсан өрхийн эмэгтэйчүүдийн 94.7 хувь, эрэгтэйчүүдийн 92.9 хувийг тус тус төлөөлсөн байна.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл боловсруулалтыг статистикийн STATA программ ашиглан гүйцэтгэсэн. Мэдээлэл боловсруулах энэ үйл явцад дата цэвэрлэх, баталгаажуулах, дотоод болон хөндлөнгийн нийцлийн хяналт, түүврийн жингийн тооцоолол, судалгааны үр дүнгийн тооцоолол зэрэг хамаарна.

Мэдээлэл боловсруулах явцад мэдээллийн зөрүүтэй байдал бий болсон ба энэ зөрүүг ҮСХ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага хамтран хэлэлцэж, туршилт судалгааны маягтад оруулсан өөрчлөлт, тохиргооноос шалтгаалсан асуудал байгаа нөхцөлд холбогдох хэсгийг тайлангаас хасах байдлаар шийдвэрлэхээр ярилцсан юм.

ӨРХИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ БАЙДАЛ


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Монгол Улс нийт 897,427 өрх, 3,197,020 хүн амтай гэсэн дүн гарчээ.

МОНГОЛ УЛСАД



Монгол Улсын нийт өрхийн дийлэнх хувийг (46 хувь) хоёр том хүн, хүүхдүүд гэсэн бүтэцтэй гэр бүл бүрдүүлдэг. Нийт өрхийн 6 хувь нь хүүхдүүдтэйгээ ганцаараа амьдардаг эмэгтэйчүүд байдаг бол нийт өрхийн зөвхөн нэг хувь нь хүүхдүүдтэйгээ ганцаараа амьдардаг эрэгтэйчүүд байдаг гэсэн тооцоо бий. Монгол улсын хүн амын 10 гаруй хувь нь хүрээлэн буй орчноос хамааралтай байдлаар аж байдлаа залгуулдаг. Мал аж ахуй эрхлэх нь байгаль, хүрээлэн буй орчинтой шууд холбоотой амьжиргаа залгах түгээмэл үйл ажиллагаа бөгөөд гэр бүлийн эрэгтэй, эмэгтэй гишүүн бүрийн орлогын эх үүсвэр болдог. (Зураг 1).

Зураг 1: Амьжиргааны болон орлого олох зорилгоор хүрээлэн буй орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг хүн амын тоо, хүйсээр (хувь)



Тайлбар: Судалгаанд хамрагдсан иргэдийн хариултуудыг хэрэв өрхийн хэрэглээндээ зориулан жимс, хүнсний ногоо, шувуу үржүүлэг, мал аж ахуй, ан агнуур, гахай, зөгийн аж ахуй, модны үйлдвэрлэл, түлш, ус зөөх, уул уурхай, үр тариа боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг бол амьжиргааны эх үүсвэртэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн ангилалд харин судалгаа авахаас хамгийн багадаа 7 хоногийн өмнөөс дээр дурдсан үйл ажиллагааг орлого олох зорилгоор эрхэлсэн бол орлого олох зорилготой байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхлэгч хэмээн ангилав. Хэрэв амьжиргааны эх үүсвэрээ бий болгох болон орлого олох гэсэн давхар зорилгоор үйл ажиллагаа эрхэлдэг гэж хариулсан бол судалгаанд хамрагдагсдаас хамгийн хамааралтай хариултаас сонголт хийхийг хүсэлт болгосон юм. Амьжиргаагаа залгуулах зорилгоор хүрээлэн буй орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Судалгаанд хамрагдсан нийт иргэд бүгд амьдралынхаа туршид уур амьсгалын өөрчлөлттэй тулгарч байжээ. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн дөрөвний нэг нь мэдээлэл цуглуулахаас өмнөх 12 сарын хугацаанд хамгийн багадаа нэг удаа гамшигт нэрвэгдэж байжээ.


ҮР ДҮН

I БҮЛЭГ. ГАМШИГТ ӨРТӨХ БАЙДАЛ, БЭЛЭН БАЙДАЛ, ҮР ДҮН

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН 4 ХҮН ТУТМЫН 1 НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ БҮС НУТАГТ АМЬДАРДАГ.

Монгол Улсын нийт хүн амын 27 гаруй хувь нь усны сан, үйлдвэрийн байгууламж, цахилгаан станц, өндөр хүчдэлийн шугам, хогийн цэг зэрэг байгаль орчны эрсдэл өндөртэй бүс нутагт амьдарч байна. Энэ нь хүн амын гамшиг болон бусад аюулт үзэгдэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг (Зураг 2). Хот суурин газарт амьдардаг эмэгтэйчүүд эрсдэлд өртөх магадлал илүү хүн амын бүлэгт хамаардаг. Цаашлаад эрэгтэй хүнтэй харьцуулахад эмэгтэй хүний гамшиг, аюулт үзэгдлийн хор нөлөөг даван туулах чадавх ихэнх тохиолдолд сул байдаг бөгөөд энэ нь өмч, хөрөнгийн эзэмшил, санхүүгийн эрх чөлөө, өндөр орлоготой ажил эрхлэх боломж бага байдагтай холбоотой.

Зураг 2: Хүрээлэн буй орчны эрсдэл өндөртэй байршил, газар нутагт амьдардаг хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйс болон байршлаар, хувь




Тайлбар: Байгаль орчны эрсдэл өндөртэй газруудад далайн эрэг; аж үйлдвэрийн байгууламж; будагч бодис, өнгөлөгч болон бусад химийн бодис ашигладаг гар урлалын үйлдвэрүүд; олборлох үйлдвэрлэл эрхэлдэг газар; тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим өндөр бүс; хогийн цэг эсвэл талбай; цахилгаан станц эсвэл өндөр хүчдэлийн шугам; шатаах/чандарлах байгууламж; ил задгай бие засах; дунд болон том хэмжээний газар тариалангийн талбай; нийтийн септик систем, газар доорх хадгалах сав эсвэл газар доорх хог хаягдлын агуулах; аж үйлдвэрийн түвшний малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх газар; хадгалах байгууламж; нам дор газар, намаг, үерт өртөмтгий газар; идэвхтэй галт уул, хагарлын шугам/газар хөдлөлтөд өртөмтгий; циклон/хар салхи/хүчтэй салхинд өртөмтгий газар; хазайсан гол/намаг ихтэй газар эсвэл үерт автдаг бусад газар; ой модыг устгасан эсвэл ган гачигт өртөмтгий бусад газар хамаарна. Тус ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

СУДАЛГААНД ХАМРАГДСАН НИЙТ ХҮН АМЫН ДӨРӨВНИЙ НЭГ НЬ СҮҮЛИЙН 12 САРЫН ХУГАЦААНД ЯМАР НЭГ ТӨРЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН БӨГӨӨД ОЛОНХ НЬ ОЛОН УДАА ГАМШИГТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН БАЙНА.

2021 оны эцсийн байдлаар, нийт хүн амын 26 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн багадаа нэг удаа гамшигт үзэгдэлд өртсөн гэсэн тоон мэдээлэл байдаг. Үүнээс гадна нийт иргэдийн 9 хувь нь хоёр ба түүнээс дээш удаа гамшигт үзэгдэл эсвэл түүнтэй холбоотой аюулд өртсөн гэсэн тооцоо бий (Зураг 3). Үүнд: хүчтэй аадар бороо, газар хөдлөлт, үер, цас, мөндөр, хүйтний эрч чангарч, цахилгаан, усан хангамжийн тасалдал үүсэж, эрүүл мэнд, эдийн засагт ноцтой хохирол учруулсан үзэгдлүүд хамаарна. Тэр дундаа мал аж ахуй эрхэлдэг хүн амын (малчдын) хувьд хүйтний улиралд тохиох аливаа гамшигт үзэгдэл нь малын эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул эдийн засгийн хортой үр дагаврыг бий болгодог байна.


Зураг 3: Сүүлийн 12 сарын хугацаанд нэг буюу хэд хэдэн удаагийн гамшигт үзэгдэл, түүнтэй холбоотой аюулд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)



Тайлбар: Эмэгтэй, эрэгтэй хүмүүст аль алинд нь хамгийн их тохиолддог аюулд: аянга цахилгаан, шүүрга, газар хөдлөлт, үер, цас, мөндөр, зуд хамаарна. Ковид-19 цар тахалтай холбоотой хариулыг энэ дүн шинжилгээ болон энэ тайлангийн бүх графикаас хассан болно.

Эдгээр гамшигт үзэгдэл, түүнтэй холбоотой аюулын улмаас нийт хүн амын 4 хувь нь зам боогдох, зах зээл хаагдах, тээврийн үйлчилгээ хязгаарлалтад орох зэрэг нөхцөл байдлаас үүдэн эмнэлгийн тусламж, эрүүл ахуйн бүтээгдэхүүн авахад хүндрэл, бэрхшээлтэй тулгарсан байна. Хот суурин газарт амьдардаг хүмүүс алслагдсан бүс нутагт амьдардаг хүмүүсээс бага зэрэг илүү бэрхшээлтэй тулгардаг гэсэн дүн гарчээ. Ерөнхийлөн үзвэл судалгааны мэдээлэл цуглуулалт Ковид цар тахлын үед хийгдсэн тул судалгаанд хамрагдсан иргэдийн 13 хувь нь дээр дурдсан гамшигт үзэгдлийн улмаас тодорхой тусламж, үйлчилгээ авч чадахгүй бэрхшээлтэй тулгарч байжээ. Гэхдээ Ковид-19 цар тахалтай холбоотой саад, бэрхшээлээс үл хамааран, байгалийн гамшигт үзэгдэл, түүний хор нөлөө нь газарзүйн байршлаас хамаарч нөхцөл байдлыг улам дордуулсан гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 2-3 хувь нь үзсэн байна (Зураг 4).


Зураг 4: Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртөж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл ахуйн бүтээгдэхүүн авахад хүндрэлтэй тулгарсан хүн амын эзлэх хувь, хүйс, байршлаар (хувь)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Гамшиг болон бусад аюулт үзэгдэлд өртөх үед хүмүүс олон төрлийн хариу үйлдэл, стресс, үй гашуу, сэтгэл гутрал, сэтгэл түгших, гэмтлийн дараах стрессийн эмгэг зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн олон асуудалтай тулгардаг бөгөөд энэ нь дээрх үзэгдлийн дараа шаардлагатай хоол хүнс, ус, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зэрэг хүний суурь хэрэгцээгээ хангаж чадах эсэхэд эргэлзэж байгаатай холбоотой бий болдог. Харин Монгол улсын хувьд дээр дурдсан гамшиг, аюулт үзэгдлийн нөлөө хүн амын харьцангуй бага хувьд нөлөөлдөг бөгөөд гамшиг, аюулт үзэгдэлд өртсөн иргэдийн 3 хүрэхгүй хувь нь дээр дурдсан мэдрэмж, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгарсан байна (Зураг 5).

Зураг 5: Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртсөн, үүний улмаас сэтгэцийн эрүүл мэнд нь хохирсон хүн амын эзлэх хувь, хүйсээр




Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ НЬ ИРГЭДИЙН АМЬЖИРГААНД ТОМООХОН ХОР ХӨНӨӨЛ УЧРУУЛДАГ БА ЭДГЭЭР НЬ ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНД ЯЛГААТАЙ БАЙДЛААР НӨЛӨӨЛДӨГ БАЙНА.

Орлогын эх үүсвэр нь хүрээлэн буй орчинтой холбоотой, хамааралтай үйл ажиллагаа эрхэлдэг иргэдэд энэхүү сөрөг нөлөө нь илүү мэдрэгдэж, гамшгийн үр дагаврыг илүү амсах магадлалтай байдаг (Зураг 6). Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад гамшигт үзэгдэлд илүү өртөж, хувийн орлогын хэмжээ нь буурах хандлагатай байв. Гамшиг, аюулт үзэгдэлд өртөж, өсгөсөн малаа алдсан эмэгтэйчүүдийн 12 хувь, эрэгтэйчүүдийн 17 хувь нь мал нь хүндээр өвчилж, хорогдсон, эмэгтэйчүүдийн 3 хувь, эрэгтэйчүүдийн 5 хувь нь гамшигт өртсөний улмаас орлого нь шууд буурсан гэж хариулжээ. Үүний гол шалтгаан нь эдгээр эрэгтэй, эмэгтэй иргэдийн орлогын эх үүсвэр нь хүрээлэн буй орчны нөөцөөс ихээхэн хамааралтай байгаа явдал юм (Зураг 7). Малаа гамшигт үзэгдэлд алдсан эсвэл мал нь хүндээр өвдсөн 10 эмэгтэй тутмын 3 нь мал аж ахуй бол тэдний орлогын эх үүсвэр гэж тодорхойлсон байна. Харин эрэгтэйчүүдийн хувьд малаа гамшигт алдсан, мал нь хүнд өвчин туссан 10 эрэгтэй тутмын 4 нь мал аж ахуйг орлогын гол эх үүсвэр хэмээн үзсэн хэдий ч эрэгтэй малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү олон тооны малыг дангаар өмчилдөг нь тэдний гамшгийн үр дагаврыг даван туулах чадварыг нэмэгдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг мөн бүрдүүлдэг байна.


Эрэгтэй малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү олон өмчтэй, олон тооны малтай байдаг тул малаа алдах, малын хорогдол гарах зэргийг илүү түлхүү анзаардаг байна. Эмэгтэйчүүд өмч, хөрөнгө эзэмших байдал харьцангуй бага байдаг нь аливаа төрлийн зээл, тусламж авах боломжийг хязгаарладаг ба энэ нь эмэгтэйчүүдийн аливаа гамшиг, аюулт үзэгдлийн сөрөг нөлөөг даван туулах чадварын бууруулдаг байна.

Зураг 6: Сүүлийн 12 сарын хугацаанд гамшигт үзэгдэл, аюулд өртсөн, амьжиргаа нь сүйдэж, хор хөнөөл амссан хүн амын эзлэх хувь, хүйс, амьжиргааны төрлөөр (хувь)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 7: Газар тариалан, мал аж ахуй нь гамшигт өртсөн, хор хөнөөл амссан иргэдийн хүн амд эзлэх хувь, хүйсээр, орлогын гол эх үүсвэр байсан эсэх (хувь)




Тайлбар: Өсгөсөн мал нь хорогдсон эсвэл хүнд өвчин туссан эрэгтэй, эмэгтэй малчид гэсэн ангилалд л зөвхөн статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан болно. ($p < 0.05$)

ХЭДИЙГЭЭР ОРШИН СУУГАА ГАЗАРТАА ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АМЬДРАХ БОЛОМЖТОЙ Ч 2021 ОНД ТОХИОСОН ГАМШИГТ ҮЗЭГДЛИЙН УЛМААС ОЛОН ХҮН ӨӨР НУТАГ ОРОН РУУ НҮҮЖ, ШИЛЖИН СУУРЬШЖЭЭ.

2021 онд болсон гамшигт үзэгдэл нь Монгол улсын эдийн засагт тодорхой хэмжээнд сөрөг нөлөө үзүүлж, тээвэр, нийлүүлэлтийн сүлжээнд зарим саатал бий болоход нөлөөлсөн боловч иргэдийн амьжиргаа, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд буюу өөр газар нутаг руу нүүх, шилжин суурьших хэмжээнд нөлөө үзүүлээгүй юм. Эдгээр гамшигт өртсөн хүмүүсийн ердөө 1 хувь нь л өөр бүс нутаг руу шилжин суурьшсан байна. (Зураг 8). Гэхдээ нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол малчдын хувьд нутаг сэлгэн нүүх нь гамшгийн улмаас өөр нутаг орон руу нүүхтэй ижил ойлголт биш байж болох талтай учир дээр дурдсан үр дүн гарсан байх магадлалтай. Цаашилбал, малчдын 16 болон 25 хувийг тус тус хамруулдаг нийгмийн даатгал,⁶ эрүүл мэндийн даатгалын үндэсний тогтолцоо нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн эдийн засгийн тогтвортой байдал, даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж, улмаар болзошгүй нөлөөлөл, нүүх, шилжих эрдслийг бууруулсан байх боломжтой. Үүний нэгэн адил, хамгийн сүүлийн үеийн мэдээллээр нийт малчдын 15 орчим хувь нь хувийн даатгалын байгууллагад даатгуулсан байгаа бөгөөд энэ нь тэдний гамшгийн сөрөг нөлөөг даван туулахад тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлж байна.⁷

Зураг 8: Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртсөн, үүний улмаас түр болон байнгын нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр, нүүлгэн шилжүүлэлтийн төрлөөр (хувь)



Тайлбар: “Өөр улс руу шилжин суурьшсан” болон “албадан нүүлгэн шилжүүлэлтийн өөр хэлбэрт өртсөн” ангилалд хамаарах тохиолдолд бүртгэгдээгүй. Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

6 Дэлгэрэнгүйг www.ilo.org/resource/brief/extending-social-protection-coverage-among-mongolian-herders-closing-social.

7 Дэлгэрэнгүйг <https://profconso.com/index-based-livestock-insurance-mongolia/> and www.gfdrr.org/sites/default/files/publication/Index-based%20livestock%20insurance%20in%20Mongolia-%20protecting%20herders%20from%20climate%20related%20livestock%20mortality.pdf.


ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ ИРГЭДИЙН АМЬДАРЧ БУЙ ОРОН СУУЦАНД ИХ ХЭМЖЭЭНИЙ ХОХИРОЛ УЧРУУЛСАН Ч ӨРХ ГЭРИЙН ЦАЛИНГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЧААЛЛЫГ ТӨДИЙЛӨН НЭМЭЭГҮЙ БАЙНА.

Монгол улсад эмэгтэйчүүд өдөрт дунджаар 291 минутыг цалин, хөлсгүй гэрийн ажилд зарцуулдаг бол эрэгтэйчүүд 103 минут зарцуулдаг байна.⁸ Гамшиг, аюулт үзэгдлийн дараа үүсдэг ундны эх үүсвэр, цахилгааны тасалдал, цахилгаан хангамжийн сүлжээний саатал, хоол хүнс, усны хомсдол зэрэг хүндрэл нь өрх гэрийн цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэх ачааллыг нэмэгдүүлдгээс гадна гамшгийн нөлөөлөлд өртсөн орон гэрээ засах, сэргээх ажилд илүү их цаг зарцуулахад хүргэдэг байна. Харин Монгол улсын хувьд сүүлийн 12 сарын хугацаанд гамшигт, аюулт үзэгдлийн улмаас эрэгтэй, эмэгтэй иргэдийн 2 хүрэхгүй хувь нь л гэрийн ажилд зарцуулах цаг хугацаа нэмэгдсэн гэж хариулжээ (Зураг 9). Энэ үзүүлэлтийн хувь ийнхүү бага байгаа нь өвлийн улиралд тохиолддог зуд г.м гамшигт үзэгдэл нь их хэмжээний бороо, хур тунадас, хүчтэй салхитай харьцуулахад хүний эрүүл мэндэд харьцангуй бага хохирол учруулдаг онцлогтой нь тодорхой хэмжээгээр холбоотой байж болох юм. Мөн түүнчлэн, улсын хэмжээнд зудын гамшиг, эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн харьцангуй хүчирхэг дэд бүтэц, өргөн газар нутгийг хамарсан хамгаалалтын сүлжээ, Зудын эрсдэлийг даван туулах, хариу арга хэмжээ авах нэгдсэн төлөвлөгөө зэргийн хэрэгжилт нь эрэгтэй, эмэгтэй малчин иргэдэд үзүүлэх гамшгийн сөрөг нөлөөг бууруулахад дэмжлэг болжээ.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 15 орчим хувь нь зудын гамшгийн улмаас орон гэр нь тодорхой хэмжээнд эвдрэл, гэмтэл авсан гэж хариулсан бол судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 4 хувь, эрэгтэйчүүдийн 3 хувь нь орон гэр нь гамшгийн улмаас бүрэн сүйдсэн гэж хариулсан ч цалин, хөлсгүй гэрийн ажлын ачааллыг төдийлөн нэмээгүй, харьцангуй бага нөлөө үзүүлсэн байгаа нь анхаарал татаж байгаа юм (Зураг 10). Монгол улсын хүн амын бараг 10 хүн тутмын 4 нь (38 хувь) нь задалж, угсарч, хялбар хурааж, ачаалж болдог уламжлалт гэрт амьдардаг бөгөөд иргэдийн энэхүү орон байр эвдрэл гэмтэл багатай, засвар үйлчилгээ харьцангуй бага шаарддаг тул аливаа төрлийн гамшиг, аюулт үзэгдлийн дараа засвар хийхэд шаардагдах хугацаа харьцангуй бага байж болох юм. Хөдөө орон нутагт амьдарч буй айл өрхийн 85 орчим хувь нь гэрт амьдардаг хагас нүүдэлчин амьдралын хэв маягтай бөгөөд аюулт үзэгдэл, гамшиг ойртож байгааг урьдчилан мэдсэн нөхцөлд, амьдарч буй байршлаа өөрчлөх боломжтой байдаг.

Судалгааны түүвэрт сонгогдсон айл өрх, иргэдээс гамшиг, аюулт үзэгдлийн улмаас усан хангамж тасалдсан, цахилгаан тасарсан гэсэн хариулт огт ирээгүй байна. Цаашлаад судалгаанд хамрагдсан иргэдийн 1 хүрэхгүй хувийг төлөөлөх иргэд аадар бороо, мөндрийн улмаас нийтийн тээврийн үйлчилгээ авах боломжгүй болсон гэж хариулжээ. Эдгээр хүмүүсийн дийлэнх нь хот суурин газар амьдардаг иргэд байна.


Зураг 9: Сүүлийн 12 сарын хугацаанд гамшиг, аюулт үзэгдэлд өртсөний улмаас цалин, хөлсгүй гэрийн ажил, асаргаанд зарцуулсан цагийн нэмэгдэл, хүйсээр, цалин хөлсгүй гэрийн ажлын төрлөөр (хувь)



Тайлбар: Хүүхэд асрахад зарцуулах цагийн ачаалал нэмэгдсэн гэж хариулсан оролцогч гараагүй. Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).


8 AXБ (2022), Монгол улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтөд жендерийн тэнцвэргүй байдлын үзүүлэх нөлөө, хуудас 9. Дэлгэрэнгүй мэдээллийг www.adb.org/sites/default/files/publication/850426/eawp-056-gender-equality-economic-growth-mongolia.pdf.

Зураг 10: Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртөж, орон байр нь эвдэрсэн, сүйрсэн хүн амын эзлэх хувь, хүйс болон хохирлын түвшингээр (хувь)



Тайлбар: “Орон сууц нь эвдэрсэн” гэх ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 11: Сүүлийн 12 сарын хугацаанд аюулд өртөж, нийтийн тээврээр зорчих боломжгүй болсон хүн амын эзлэх хувь, хүйс болон байршлаар (хувь)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

БОЛОМЖТОЙ БҮХ НӨХЦӨЛД АЮУЛЫН ТАЛААР ЭРТ СЭРЭМЖЛҮҮЛЭХ НЬ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АМИН ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ БОЛДОГ.

Эмэгтэйчүүдийн 76 орчим хувь, эрэгтэйчүүдийн 66 хувь нь 2021 онд улс орон даяар тохиолдсон зудын талаар урьдчилан сэрэмжлүүлэх мэдээлэл авсан нь тэднийг гамшгийн эрсдэлээс сэргийлэх, бэлтгэхэд дэмжлэг үзүүлжээ. Харин 2021 оны нэгдүгээр сард Хөвсгөл нуурын сав газарт болсон газар хөдлөлтийн талаарх мэдээлэл хамгийн бага хүмүүст хүрч, нутгийн иргэдийн дөнгөж 13 хувь нь л урьдчилсан мэдээлэл авчээ. Хэдийгээр эрэгтэй, эмэгтэй иргэдийн дийлэнх нь аливаа гамшиг, аюулт үзэгдлийн талаарх сэрэмжлүүлэг мэдээллийг хүлээн авсан байдаг ч мэдээлэл хүлээн авах сувгийн хувьд хүйсийн ялгаатай байдал ажиглагдав. Эрэгтэйчүүдийн хувьд мэдээлэл хүлээн авдаг гол суваг нь орон нутгийн удирдлага, захиргааны байгууллага бол эмэгтэйчүүдийн хувьд хөрш, орон нутгийн иргэд, мэдээлэл хүргэгч иргэд байв.

Мэдээлэл хүлээн авах суваг хүйсээр болон хот, хөдөөгөөр ялгаатай байна (Зураг 12). Хот суурин газруудад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад нутгийн захиргаанаас эсвэл радиогоор дамжуулдаг мэдээлэлд түлхүү найддаг бол эмэгтэйчүүд олон нийт, хөрш, мэдээлэл түгээгч нарт илүү найдаж сонсдог байна. Харин хөдөө орон нутагт эмэгтэйчүүд утсаараа дамжуулан эрт сэрэмжлүүлэх мэдээлэл түлхүү авдаг байсан бол эрэгтэйчүүд интернэт болон орон нутгийн иргэд, хөршүүдээс илүү мэдээлэл авдаг байна. Хот суурин газрын үерийн гамшигт үзэгдлээс бусад тохиолдолд гамшгаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай

мэдээлэл нь гамшгаас урьдчилан сэргийлэхэд тустай гэдгийг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүүтэй сайн ойлгож анзаарч байсан бөгөөд үүнд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад мэдээллийг харьцангуй хожуу авдаг магадлал бага байсан.


Зураг 12: Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртсөн хүн амын гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдлын эзлэх хувь, хүйсээр, гамшигт үзэгдлийн төрлөөр (хувиар)



ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХАД ХҮЙСИЙН ЗӨРҮҮТЭЙ БАЙДАЛ ҮҮССЭНЭЭР АЮУЛ, ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХАД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ИРГЭД ХООРОНД ЯЛГААТАЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ БИЙ БОЛЖ БАЙНА.

Гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл авах явдал эрэгтэй, эмэгтэй иргэдийн хувьд ялгаатай байгаа нь гамшиг, аюулт үйл явдлаас сэргийлэх, бэлэн байдлаа хангахад мөн ялгаатай байдлыг бий болгож байна. Гамшиг, аюулт үзэгдлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь авсан хүмүүсийн хувьд бэлэн байдлаа хангаж чадсанаар эрүүл мэнд, амьжиргаагаа хамгаалж чадсан нь мэдээлэл чухал гэдгийг харуулж байдаг. Нийгмийн тогтсон хэм хэмжээ, хандлага болон бусад хүчин зүйл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гамшиг, аюулт үзэгдэлд бэлтгэх бэлтгэлд тодорхой хэмжээнд нөлөөлж болно. Мал сүргээ аюулгүй газарт хүргэх, туух ажилд хүйсийн ялгаатай байдал байхаас гадна энэ нь мал ихэнх тохиолдолд эрэгтэй хүмүүсийн өмчлөлд байдагтай холбоотой байх магадлалтай бөгөөд судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 9 хувь нь малаа өмчилсөн байдаг бол эрэгтэйчүүдийн 15 хувь нь малаа өөрийн өмч болгосон, нийт эрчүүдийн 40 хувь мал сүргээ хэрхэн захиран зарцуулах талаар шийдвэр гаргадаг бол эмэгтэйчүүдийн 10 хувь нь л энэ төрлийн шийдвэр гаргахад оролцоотой байдаг ажээ. Нийт өрхийн 25 хувь нь мал аж ахуй эрхэлдэг⁹ Монгол орны онцлог нөхцөл байдалд нийцүүлэн гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь орон байр, малын хашаа, хороо г.м байгууламжийн барилгын материалыг сайжруулах, мал сүргээ туух, аюулгүй газар хүргэх зэрэг арга хэмжээнд түлхүү төвлөрдөг байна. (Зураг 13).

Зураг 13: Сүүлийн 12 сарын хугацаанд аюул, гамшигт үзэгдэлд өртсөн хүн амаас гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан иргэдийн эзлэх хувь, хүйсээр, арга хэмжээний төрлөөр (хувиар)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

II БҮЛЭГ. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨНД ӨРТӨХ БАЙДАЛ БА ТҮҮНИЙ СӨРӨГ НӨЛӨӨГ ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ


УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ, ТЭР ДУНДАА ХЭТ ХҮЙТРЭХ, ЗУДЫН ГАМШГИЙН ДАВТАМЖ НЭМЭГДЭЖ БАЙГАА НЬ МОНГОЛ УЛСЫН ХҮН АМД НӨЛӨӨЛЖ БАЙНА.

Жендэр ба хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгаанд уур амьсгалын өөрчлөлтүүдийн дүнд бий болсон гамшиг, аюулт үзэгдлүүдийн нарийн тоо, давтамж, тухайлбал температурын өсөлт, агаарын бохирдлын үзүүлэлт г.м нарийн үзүүлэлт хэмжихэд чиглэсэн асуултууд багтаагүй. Гэхдээ судалгаанд хамрагдсан иргэдээс гамшиг, аюулт үзэгдэл тэдний өдөр тутмын амьдралд ямар онцгой нөлөө үзүүлж байгааг тодруулж асуусан болно. Зураг 14-т үзүүлсний нэгэн адилаар, зудаас гадна өвлийн улиралд хэт хүйтрэх, энэхүү хүйтэн цаг уурын үргэлжлэх хугацаа уртсах зэрэг гамшиг, аюулт үзэгдлийн улмаас ихэнх иргэдийн орлогод сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тодруулбал судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 12 хувь, эрэгтэйчүүдийн 11 хувь нь цаг агаар илүү урт хугацаанд хүйтэрч, температур буурснаар өрхийн орлогод сөргөөр нөлөөлсөн хэмээн хариулжээ. Цаг уурын статистик мэдээллээс харахад Монгол орны дундаж температур 1940 оноос хойш цельсийн 2 хэмээр нэмэгдсэн үзүүлэлт байгаа ч мөн адил хугацаанд унасан хур тунадас, цасны хэмжээ нэмэгдсэн байна.¹⁰ Үүний нэгэн адил зуны дулаан өдрүүдийн тоо нэмэгдсэн боловч хүйтний улирал, өдрүүдийн температурт эрс тэс өөрчлөлтүүд гарч байна. (2016 оноос хойш хэт хүйтэн өдрүүдийн тоо ойролцоогоор 30 хувиар, өвлийн улиралд унах цас, хур тунадасны хэмжээ 1960-аад оноос хойш 40 хувиар нэмэгдсэн байна)¹¹. Ой хээрийн түймэр, агаарын бохирдол, биологийн олон янз байдлын алдагдал зэрэг нь нийт хүн амын 3 орчим хувийн амьжиргаанд нөлөөлсөн нь санаа зовоож болзошгүй асуудал гэдгийг илтгэж байна. Цаг уурын өөрчлөлтийн сөрөг нөлөө эрэгтэй, эмэгтэй хүнд ялгаагүй орлого буурсан үр дагавар авчирсан учир уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд онц ач холбогдолтой хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.

¹⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг www.unicef.org/mongolia/media/4921/file/English.pdf.

¹¹ Дэлгэрэнгүй мэдээллийг <https://e360.yale.edu/features/mongolia-dzud-climate-change>.

Зураг 14: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 5 жилд орлого болон бусад эх үүсвэрийн хэмжээ нь буурсан хүн амын эзлэх хувь, хүйсээр болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөний төрлөөр (хувь)




Тайлбар: Агаарын бохирдол гэсэн хариултын төрлөөс бусад төрөлд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ НЬ ТҮҮНИЙ СӨРӨГ НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫГ БУУРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХОД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ. МОНГОЛ УЛСАД ИРГЭДИЙН ЗӨВХӨН 15 ХУВЬ НЬ ТЕМПЕРАТУР ОГЦОМ БУУРАХ ҮЗЭГДЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВСАН БАЙДАГ.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл авах арга зам хялбар бус, мэдээлэл хомс эсвэл энгийн, ойлгомжтой байгаагүйн улмаас уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар иргэдийн эрүүл мэнд, амьжиргаа, байгаль орчны тогтвортой байдалд илүү сөргөөр нөлөөлж, дордуулдаг. Монгол улсад ойролцоогоор хүн амын 71 хувь нь цаг агаар хүйтэрч, температур огцом доошлох тухай мэдээллийг урьдчилан авч чадсан нь гамшиг, аюулт үзэгдэл болоход бэлэн байх, дасан зохицох боломжийг нь нэмэгдүүлэхэд дэмжлэг болжээ. Мэдээлэлтэй байсан эдгээр хүмүүсийн дийлэнх олонх нь (79 хувь) цаг агаар хүйтэрэх тухай мэдээллийг телевиз, интернэтээс авсан байна. (Зураг 15). Эндээс харахад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, дасан зохицох, нийт орон даяар байгаль орчны тогтвортой байдлыг дэмжихэд чиглэсэн мэдлэг, мэдээлэл олгоход дээр дурдсан сувгуудыг түлхүү ашиглах нь чухал байна. ТХЗ-ын мэдээллийн сан дахь статистик мэдээллээс харахад Монгол улсад хүүхэд, өсвөр үед тогтвортой хөгжлийн боловсрол, мэдлэг, ойлголтыг боловсролын тогтолцоогоороо дамжуулан амжилттай хүргэж байгаа бөгөөд ингэхдээ үндэсний боловсролын бодлогоор дамжуулж (1-ээс 0.875), сургалтын хөтөлбөрөөр дамжуулж (1-ээс 0.75) мөн багшийн боловсролыг дээшлүүлэх замаар (1-ээс 0.85) хүргэж байна.¹² Ийнхүү мэдлэг, ойлголтыг хүүхдийн эрт насанд суулгаж, ойлгуулах нь чухал ач холбогдолтойн дээр уур амьсгалын өөрчлөлт хурдацтай өсөн нэмэгдэж, түлгэмдсэн асуудал, яаралтай авах арга хэмжээ улам бүр нэмэгдэж байгаа энэ үед тогтмол давтамжтай мэдээллээр давхар хангаж байх нь мөн чухал юм. Эрэгтэй хүмүүс эмэгтэйчүүдтэй харьцуулахад уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг телевизээр түлхүү авдаг гэж хариулсан нь мэдээллийг нийт хүн ам, иргэдэд тэнцвэртэй хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны олон суваг, платформ ашиглан дамжуулахын чухлыг харуулж байна.

Зураг 15: Цаг агаар огцом хүйтэрэх, түүний нөлөө, үр дагаврын талаарх мэдээллийг олон төрлийн сувгаар авсан иргэдийн эзлэх хувь, хүйсээр, мэдээллийн эх сурвалжаар (хувь)




Тайлбар: “Нийгэм/найз нөхөд”, “орон нутгийн удирдлага”, “радио” гэсэн хариулт өгсөн оролцогчдын тоо 25-аас бага тул болгоомжтой тайлбарлах хэрэгтэй. Эдгээр 3 төрөлд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАВАН ТУУЛАХАД ЭМЭГТЭЙЧҮҮД АВАХ ЁСТОЙ ХООЛ ТЭЖЭЭЛЭЭ ХАСАХ, ЗОЛИОС ГАРГАХ ТОХИОЛДОЛ ТҮЛХҮҮ БАЙДАГ.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бий болсон аюулт нөхцөл байдлын үед эмэгтэйчүүдийн 2.3 хувь нь, эрэгтэйчүүдийн 1.9 хувь нь орлого буурсны улмаас хоол хүнс харьцангуй бага хэрэглэсэн гэж хариулжээ. (Зураг 16). Энэ тоо хэдийгээр хүн амын багахан хэсгийг илэрхийлж байгаа ч эхлээд хямд, тэжээллэг чанар багатай хоол хүнс сонгон авах, дараа нь хоол, хүнсний хэрэглээгээ эрс багасгах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг даван туулах иргэдийн энэ арга стратеги нь эрүүл мэндийн олон асуудал дагуулах эрсдэлтэй юм. Хоол, хүнсний хэрэглээгээ багасгасан иргэдийн дийлэнх нь хөдөө орон нутагт амьдардаг байна. Монгол улсад хүнсний ногоо, жимс жимсгэнийн олдоц хязгаарлагдмал тул уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө эдгээр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй. Дэлхийн хүнсний статистик тоо баримтаас харахад Монгол улсын хүн ам байнга хэрэглэдэг, гаднаас импортоор авдаг улаан буудай, төмс хоёрын үнэ 2007¹³ оноос хойш огцом өссөн нь нэг талаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй. Хэрэв энэ хандлага үргэлжилбэл Монгол эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, аж байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Зураг 16: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүнсний хэрэглээ нь буурсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)




УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ НЬ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН АЧААЛАЛ, ДАРАМТЫГ УЛАМ НЭМЭГДҮҮЛДЭГ.

Уур амьсгалын хямралаас үүдэлтэй температурын өөрчлөлт, хур тунадас орох горим, биологийн төрөл зүйл, бохирдол, усны чанар болон бусад олон зүйлд урт хугацаанд гарч буй өөрчлөлт нь хүний эрүүл мэндэд томоохон эрсдэлийг дагуулдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монгол улсын эмэгтэйчүүдийн 8 хувь, эрэгтэйчүүдийн 7 хувь нь эрүүл мэндээрээ хохирсон гэсэн тооцоо байна. (Зураг 17). Уур амьсгалын өөрчлөлт нь амьсгалын замын болон зүрх судасны өвчин, булчингийн тогтолцооны өвчин, халдвар тээгч, усаар дамждаг өвчлөл зэрэг хүний эрүүл мэндийн бусад асуудлуудтай шууд холбоотой байдаг. Монгол орны хувьд бага температур, ой хээрийн түймэр, агаарын бохирдол зэрэг нь эрүүл мэндэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг, амьсгалын замын болон булчингийн тогтолцооны хямрал нь цаг уурын өөрчлөлттэй шууд холбоотой гэж судалгаанд хамрагдагсад хариулжээ. Үүнээс гадна эмэгтэйчүүдийн 5 хувь, эрэгтэйчүүдийн 3 хувь нь уур амьсгалын өөрчлөлтөөс болж сэтгэцийн эрүүл мэнд муудаж, стресс, түгшүүртэй байдал нэмэгдсэн гэж үзэж байна. Ихэнх эмэгтэйчүүдийн хувьд уур амьсгалын өөрчлөлт нь давхар дарамт үүсгэж, ажлын ачаалал нэмдэг байна. Тэд зөвхөн өөрийн эрүүл мэндээр хохирох бус гэр бүлийн гишүүд нь өвдсөн үед асрах зэрэг давхар ачаалал үүрдэг юм. Ойролцоогоор эмэгтэйчүүдийн 4 хувьд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавраас үүдэн эрүүл мэнд нь хохирсон гэр бүлийн гишүүнээ асрах цалин, хөлсгүй хөдөлмөр, ачаалал нэмэгддэг байна. Эмэгтэйчүүдийн 2 хувь нь энэ төрлийн ачаалал нэмэгдэх нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавартай шууд холбоотой гэж үзжээ. (Зураг 18).


¹³ Дэлгэрэнгүй мэдээллийг <https://data.humdata.org/dataset/wfp-food-prices-for-mongolia>.

Зураг 17: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эрүүл мэндийн өвчлөл нэмэгдсэн гэж үзсэн хүн амын эзлэх хувь, хүйс, төрлөөр (хувь)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 18: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүүхэд, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах болон гэрийн ажилд зарцуулсан цаг хугацаа нь нэмэгдсэн хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)




УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ АЖЛЫН БАЙР ЦӨӨРӨХ, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН УРГАЦ БУУРАХАД НӨЛӨӨЛЖ, УЛМААР ИРГЭДИЙН АМЬЖИРГААНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

2021 оны тоон мэдээллээс харахад уур амьсгалын хямралын улмаас нийт эмэгтэйчүүдийн 4 хувь, эрэгтэйчүүдийн 5 хувь нь ажлын байраа сольсон эсвэл ажлаа бүрмөсөн алдсан байна (Зураг 19). Уур амьсгалын өөрчлөлтийн үр дүнд байгалийн нөөцийн хүртээмж буурч, нийлүүлэлтийн сүлжээ тасалдалт, биологийн олон янз байдлын алдагдал, цаг уур, орчны нөхцөл байдалд гарч буй өөрчлөлт зэрэг нь ард иргэд, тэр дундаа аялал жуулчлал, хөдөө аж ахуй, мал аж ахуй болон бусад байгаль орчинтой холбоотой ажил, үйл эрхэлдэг хүмүүсийг ажлаа солиход нөлөөлсөн байна. Монгол орны тухайд эрэгтэй хүн ам эмэгтэйчүүдтэй харьцуулахад байгаль орчинтой холбоотой ажил, үйл ажиллагаа түлхүү эрхэлдэг хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүн амын дийлэнх олонх нь (ойролцоогоор 93 хувь)¹⁴ албан бус салбарт өөрийн амьжиргаагаа залгуулах зорилгоор мал аж ахуй эрхэлж байна. Ийнхүү ажлаа хялбар алдаж байгаа нь баталгаатай дэмжлэг, аюулгүй сүлжээ дутмаг байгаагийн илрэл юм.

14 Дэлгэрэнгүй мэдээллийг <https://iloostat.ilo.org/data/>.

Газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг иргэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг илүү түлхүү мэдэрсэн байдаг. Газар тариалан эрхэлж буй эмэгтэйчүүдийн 2 хувь, эрэгтэйчүүдийн 3 хувь нь (ашиг, орлого олох эсвэл амьжиргаагаа залгуулах, чөлөөт цагаараа тариалах, уламжлал, шашин шүтлэг болон бусад шалтгаанаар газар тариалан эрхэлсэн) сүүлийн таван жилд газар тариалан, малын ашиг шим нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр буурсан гэж тэмдэглэжээ. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж орлогын гол эх үүсвэрээ бүрдүүлдэг иргэдийн хувьд (судалгаанд хамрагдсан иргэдийн 48 ба 13 хувь) уур амьсгалын өөрчлөлт тэдний аж байдалд ноцтой нөлөөлсөн байж магадгүй. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх олон аргуудын нэг болох пестицид их хэмжээгээр хэрэглэх, антибиотик хэрэглэх, газар тариалангийн үйл ажиллагаанд илүү их цаг зарцуулах зэрэг оролдлогууд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулж чадаагүй нөхцөлд газар тариалангаас хураан авах ургацын хэмжээ буурч, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний улмаас тохиож болох хамгийн муу үзэгдэл, үр дүн гарах юм. Тиймээс зарим нөхцөлд газар тариалангийн ургац буурах эрсдэлээс зайлсхийж чадсан ч олон хүн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд өртсөн байх магадлалтайг харуулж байна.

Зураг 19: Уур амьсгалын өөрчлөлт тэдний ажлын байр, амьжиргаанд нь сөргөөр нөлөөлснийг анзаарсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)



Тайлбар: Энд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

III БҮЛЭГ. БАЙГАЛИЙН НӨӨЦ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН АЛДАГДАЛ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН БА АЖ БАЙДАЛ

МОНГОЛ УЛСАД ХҮН АМЫН ДИЙЛЭНХ НЬ БАЙГАЛИЙН НӨӨЦ, БАЯЛГААС ХАМААРАЛТАЙ БАЙГАА НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТОЛ ИРГЭДИЙН АМЬДРАЛД МАШ ИХ СӨРӨГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙГ ОНЦОЛЖ БАЙНА.

Хүн ам ийнхүү байгалийн нөөц, баялгаас шууд хамааралтай амьдарч байгаа нь Монгол улсын иргэдийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолд өртөмтгий болгож байна. Хүн амын дийлэнх олонх нь орлогын олон эх үүсвэртэй ч бараг найман хүн тутмын нэг (эмэгтэйчүүдийн 8 хувь, эрэгтэйчүүдийн 13 хувь) нь байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаанаас орлого олдог иргэд байгаа юм. Цаашлаад, нийт эмэгтэй хүн амын 11 хувь нь, нийт эрэгтэй хүн амын 16 хувь нь байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулж янз бүрийн түвшинд орлого олдог байна. Судалгаанд хамрагдсан хүн амын 12 хувь нь байгалийн баялгаас өөрөө болон гэр бүлийнхээ өдөр тутмын амьжиргааг залгуулдаг гэж хариулжээ (Зураг 20). Эдгээр хүмүүсийн хувьд байгалийн нөөцийн доройтол нь харьцангуй өндөр эрсдэл дагуулдаг.


Байгаль орчинтой холбоотой аж ахуй дотроос мал аж ахуй нь иргэдийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. (ойролцоогоор 10 хүн тутмын 7 юм) (Зураг 21). Монгол улсад мал аж ахуй эрхлэгчдийн дийлэнх нь нүүдлийн болон хагас нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг бөгөөд өндөрлөг газар, эрс тэс уур амьсгал, урт үргэлжлэх хүйтний улирал, хур тунадас бага ордог зэрэг газар нутгийн онцлог байдал нь мал аж ахуй болон байгаль орчинтой холбоотой бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлж, амьжиргаагаа залгуулахад нь сорилт, бэрхшээлийг бий болгодог юм. Эрэгтэй хүн амын тухайд орлогын олон үүсвэртэй байх нь элбэг бол эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй цөөн эх үүсвэр буюу орлогын нэг эх үүсвэртэй байдаг. Энэ ялгаа ургамал, мод, түлээ цуглуулах, ус зөөх, ан агнуур хийх, хог хаягдал боловсруулах зэрэг байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхлэхэд түлхүү тохиолддог. Хөрс, ой мод, усны нөөц болон байгалийн бусад нөөц аажмаар доройтож байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж амьжиргаагаа залгуулдаг иргэдийн хувьд эрсдэлтэй, тэднийг нөлөөлөлд өртөмтгий болгож байгаа юм.

Зураг 20: Орлогын гол эх үүсвэр нь байгаль орчинтой холбоотой хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)



Тайлбар: Ан агнуур, ургамал, үр тариа, мөөг түүж, газар тариалан, түлээ, ойн бусад бүтээгдэхүүн бэлтгэх, мал аж ахуй, уул уурхай, хог түүж, дахин боловсруулах, ус зөөх, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хатаах, боловсруулах зэрэг үйл ажиллагаанаас орлого олдог иргэнийг байгаль орчны холбогдолтой үйл ажиллагаанаас орлого олдог гэж үзнэ. Орлогын эх үүсвэр нь орлогын 50-иас доошгүй хувийг бүрдүүлдэг бол "орлогын үндсэн эх үүсвэр" гэж тодорхойлов. Амьжиргаагаа залгуулахын тулд байгаль орчны үйл ажиллагаа эрхлэх гэсэн ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 21: Орлогын эх үүсвэр нь байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйс, эрхэлж буй үйл ажиллагааны төрлөөр (хувь)



Тайлбар: Зөвхөн орлого олж буй хүмүүсийн дундаас хувийг тооцов. ХАА, уул уурхай, малын болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хатаах, боловсруулах гэсэн ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэдийн хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$)

МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛЖ БУЙ ИРГЭДИЙН ТОО ӨНДӨР УЧИР МОНГОЛ УЛС УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ГУРВАН ДАВХАР ХЯМРАЛД ӨРТӨМТГИЙ БАЙДАГ. ЭМЭГТЭЙЧҮҮД ӨӨРИЙН ӨМЧ ХӨРӨНГӨ БАГАТАЙ БАЙДАГ НЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СӨРӨГ НӨЛӨӨГ ДАВАН ТУУЛАХАД ИЛҮҮ ИХ БЭРХШЭЭЛТЭЙ ТУЛГАРАХАД ХҮРГЭДЭГ.


Монгол улсын хүн амын 11 хувь нь мал аж ахуй эрхэлж амьжиргаагаа залгуулдаг тооцоо бий. Мөн хүн амын 2 хувь нь хүнсний үйлдвэрлэл, 3 орчим хувь нь хүнсний ногоо тариалж амьжиргаагаа залгуулдаг байна. Жишээ нь эмэгтэйчүүд мал аж ахуй, газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, хатаах ажилд эрэгтэйчүүдээс илүү хамааралтай байдаг бол эрэгтэйчүүд мал аж ахуй түлхүү эрхэлдэг байна (Зураг 22). Дээр дурдсан болон байгаль орчинтой холбоотой бусад үйл ажиллагаа эрхлэгчдийн бараг бүгдэд уур амьсгалын өөрчлөлт нөлөөлж, ургац хураалт хэсэгчлэн эсвэл бүхэлдээ буурч улмаар амьжиргаанд нь сөргөөр нөлөөлдөг. Ойн жимс, жимсгэнэ түүж, ан агнуур эрхэлдэг гэж хариулсан хүмүүс эдгээр үйл ажиллагаанаас амьжиргааныхаа тодорхой хэсгийг бүрдүүлдэг гэж хариулжээ. Үүний нэгэн адил сүүлийн 12 сарын хугацаанд ус зөөх, хүнсний ногоо тариалах, хог хаягдал цуглуулах, ангилах ажил хийдэг иргэд эдгээр үйл ажиллагааны дүнд өөрийн болон өрхийн амьжиргаандаа нэмэрлэсэн гэж хариулжээ. Амьжиргаагаа залгуулахын тулд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү мал өсгөдөг, эмэгтэйчүүд нь малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах ажилд эрэгтэйчүүдээс түлхүү оролцоотой байдаг (Зураг 23).

Амьжиргаагаа залгуулахын тулд эсвэл жижиг талбайд газар тариалан эрхэлдэг олон иргэдийн хувьд байгаль орчны доройтол, биологийн олон янз байдлын алдагдал, бохирдлоос бүрдсэн уур амьсгалын өөрчлөлтийн гурван хямрал нь тэднийг уур амьсгалын өөрчлөлтөд илүү өртөмтгий болгож байна. Тэр дундаа эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөө аж ахуй, газар тариалантай холбоотой өмч, хөрөнгө бага эзэмшдэг эмэгтэйчүүдийн тухайд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг даван туулах, үр дагавартай тэмцэхэд дэмжлэг болохуйц зээл болон санхүүгийн бусад төрлийн тусламж дэмжлэг авахад саад бэрхшээл түлхүү тулгардаг гэж үзжээ. Монгол улсад газар өмчлөлийн бүрэн мэдээлэл бүхий сан байхгүй ч энэ салбарт хийсэн судалгаанаас¹⁵ харахад газар өмчлөлд жендерийн ялгаатай байдал ажиглагдсаар байна. 2018 онд хийсэн судалгааны үр дүнгээс харахад нийт эмэгтэйчүүдийн 2 хувь нь ХАА-н газар эзэмшдэг бол эрэгтэйчүүдийн 8 хувь нь ХАА-н газар эзэмшдэг байна. Энэ ялгаа Жендер ба хүрээлэн буй орчин 2021 туршилт судалгааны оролцогчид дунд мөн ажиглагдсан юм. Газар тариалан эрхэлдэг эмэгтэйчүүдийн 43 хувь, эрэгтэйчүүдийн 63 хувь нь газар өмчлөх эрхтэй, хувь хүн хөдөө аж ахуйн газраа дангаараа эсвэл өөр хэн нэгэнтэй хамтран захиран зарцуулах эрхтэй гэж хариулжээ. Энэ газраа өвлүүлэн үлдээх эрхтэй эсэхийг асуухад эмэгтэйчүүдийн 41 хувь, эрэгтэйчүүдийн 52 хувь нь өвлүүлэн үлдээх эрхтэй гэж хариулжээ.¹⁶

15 Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендерийн өнцгөөс шинжлэх нь туршилт судалгаа, 2018. Дэлгэрэнгүй мэдээллийг: <https://unstats.un.org/edge/publications/docs/Results%20of%20Pilot%20Survey%20in%20Mongolia.pdf>.


16 Газар өмчлөлтэй холбоотой асуултыг 200-с бага оролцогчоос асуусан тул үр дүнг тайлбарлахдаа анхаарч үзнэ үү.

Зургаг 22: Байгаль орчинтой холбоотой ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрлөөр (хувь)



Тайлбар: Амьжиргаагаа залгуулах, орлого олох зорилгоор байгаль орчинтой холбоотой аж ахуй эрхэлдэг иргэдийн мэдээллийг энэ зургаар илэрхийлэв. Ургамал, ногоо тарих, ан агнах, мод, үр жимс, тэжээл, мод, түлш бэлтгэх, цуглуулах гэсэн ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 23: Байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа эрхэлж амьжиргаагаа залгуулдаг хүн амын эзлэх хувь, хүйсээр, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэрээр (хувь)




Тайлбар: Үйл ажиллагаа бүрд хамаарах хугацааг судалгаа авахаас өмнөх 7 хоногийн хугацаанд хамгийн багадаа 1 цаг тус үйл ажиллагааг эрхэлсэн байна гэж тодорхойлов. Мал өсгөх, тэжээх, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, хатаах, ургац хураах гэсэн ангиллуудад эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$)

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ НЬ БАЙГАЛЬ ОРЧИНД ТҮШИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ШААРДАГДАХ ХУГАЦААГ УЛАМ УРТАСГАЖ БАЙНА.

Бороо, хур тунадасны хэмжээ, салхи, шуурганы хурд, хүч, хэт их халалт зэрэг байгаль цаг уурын нөхцөл байдлыг урьдчилан таамаглах боломжийг улам бүр хязгаарлах болсон уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчинд түшиглэн амьжиргаагаа залгуулж, орлого олдог иргэдийн тухайн үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацааг улам бүр уртасгасаар байна. Энэ байдал амьжиргаа, өөрийн хэрэгцээнд зориулж үр тариа тариалах, хатаах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг иргэдэд илүү их мэдрэгдэх болов. Дээрх үйл ажиллагаа эрхэлж буй 3 эмэгтэй тутмын 1 нь сүүлийн 12 сарын хугацаанд эдгээр үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа нэмэгдсэн гэж хариулжээ (Зураг 24). Ийнхүү илүү олон цаг зарцуулах нь ургацаа зохих хэмжээнд хураан авахад чиглэсэн хариу арга хэмжээний нэг хэлбэр юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгаль орчинд түшиглэсэн амьжиргаа залгуулах олон үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа улам бүр нэмэгдэж байна. Тэр дундаа эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн ойгоос мод, жимс, өвс, тэжээл болон бусад төрлийн бүтээгдэхүүн бэлтгэхэд зарцуулах цаг хугацаа нэмэгдсэн байна. Монгол орны ойн түймэр, хөрсний нуралт зэрэг үзэгдэл нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр маш хурдацтай дордож байгаагаас гадна биологийн олон янз байдлын алдагдал ч мөн ойн доройтол нэмэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйл юм. Өвлийн улиралд хүйтний эрч чангарч, хүйтэн өдрүүдийн тоо, давтамж нэмэгдсэнээр мал маллаж буй иргэдийн хувьд малын хашаа хороогоо янзлах, малаа аюулгүй газарт хүргэх, малаа өвчилсөн үед эмчлэх зэрэг ажлуудад зарцуулах хугацаа тэр хэмжээгээр нэмэгддэг байна.

Зураг 24: Сүүлийн 12 сарын хугацаанд байгаль орчинд түшиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн тус үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдсэн байдал, хүйсээр, (хувь)




Тайлбар: Энэ тоо нь амьжиргааны зорилгоор эдгээр үйл ажиллагааг тогтмол эсвэл хэсэгчлэн эрхэлдэг хүн амыг илэрхийлнэ. Үйл ажиллагаа тус бүрт хамаарах хугацааг судалгаа авахаас 7 хоногийн өмнө хамгийн багадаа 1 цаг зарцуулсан байх гэсэн шалгуураар тодорхойлов. Харин эдгээр үйл ажиллагааг эрхлэхэд зарцуулсан нэмэгдэл цагийг тооцохдоо сүүлийн 12 сард зарцуулсан хугацаагаар авсан болно. Мод, ургамал, тэжээл, түлш, ус, ойн бүтээгдэхүүн зөөвөрлөх, цуглуулах гэсэн ангиллуудаас бусад ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$). “Уул уурхай/олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа”, “зэрлэг ан амьтан агнах, загас барих” гэсэн ангилалд хариулсан оролцогчдын тоо 25-аас бага тул тооцооллыг тайлбарлахдаа анхаарах нь зүйтэй.

ЗЭРЛЭГ ОЙН БҮС НЬ ХҮН АМЫН АМЬЖИРГААНД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ.

Монгол улсад мал аж ахуй, мод бэлтгэх, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг 10 хүн тутмын 1 нь үндсэн ой, ойгоор бүрхэгдсэн газар, зэрлэг бэлчээр болон бусад хэлбэрийн зэрлэг ойн газрыг ургац хураах, мал сүргээ бэлчээх зорилгоор ашигладаг байна (Зураг 25). Эдгээр газар нутаг бол хүн амын амьжиргаанд чухал үүрэгтэй төдийгүй биологийн олон янз байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой билээ. Монгол орны ой мод нь нийт газар нутгийн 12 орчим хувийг эзэлдэг бөгөөд 140 гаруй төрлийн мод, сөөг, 13000 гаруй төрлийн шавьж, 372 төрлийн шувуу, 138 зүйлийн хөхтөн амьтад, мөн төрөл бүрийн хоёр нутагтан, хэвлээр явагчид байдаг.¹⁷ Энэхүү биологийн олон янз байдал нь өндөг, зөгийн бал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний ургац, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ан агнуурын аж ахуй эрхлэгчдийг дэмжиж, олон хүний аж байдлыг тэтгэж байдаг. Тухайлбал, 80 гаруй төрлийн ургамлыг хүнсний болон бусад зориулалтаар хураан авч түгээмэл ашигладаг гэсэн тооцоо бий.¹⁸ Биологийн олон янз байдал бүхий ой нь бороо, цаг уурын температур зэргийг зохицуулахад чухал үүрэгтэй байдаг учраас уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулдаг сайн талтай.

Ан агнуур, бэлчээрийн даац, уул уурхай, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөгөөр Монгол орны ойн талбай багасаж, усны эх үүсвэр, хөрсний чанар муудаж байна.¹⁹ Монгол улсын хүн ам, экосистемийн эрүүл мэнд, хөгжил цэцэглэлтийг хадгалахын тулд зэрлэг ой, хээр болон бусад ойт газрыг хамгаалах нь нэн тэргүүний зорилт хэвээр байна. Хэдийгээр Монгол улсад зэрлэг ойн үр шимийг эмэгтэй, эрэгтэй иргэд ижил хэмжээгээр хүртдэг ч 2018 онд хийсэн туршилт судалгаагаар хөдөө аж ахуйн газар эзэмшдэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байгаа нь²⁰ (эрэгтэйчүүдийн амьдран суух байр, бусад төрлийн өмч хөрөнгийн эзэмшил өндөр байдаг) эмэгтэйчүүдийг зөвхөн зэрлэг ойд түшиглэсэн үйл ажиллагаа эрхэлж амьжиргаагаа залгуулдаг, эмзэг нөхцөл байдалд хүргэж болох юм.

Зураг 25: Амьжиргааны зорилгоор зэрлэг ой, бэлчээр, ойн бүсээс малын тэжээл, мод бэлтгэх, ан агнуур хийх, малаа бэлчээж буй хүн амын эзлэх хувь, хүйсээр, (хувь)



Тайлбар: Энэ ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

17 Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.cbd.int/doc/world/mn/mn-nr-04-en.pdf>

18 Дэлгэрэнгүй мэдээллийг www.cbd.int/countries/profile?country=mn.


19 Биологийн олон янз байдлын конвенц, 2020. Дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.cbd.int/countries/profile?country=mn#:~:text=The%20area%20of%20Mongolia's%20forest,of%20insects%20discovered%20every%20year>.

20 АХБ, Монгол улсын YCX, "Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендерийн төлөв байдлаар тодорхойлох нь" судалгаа. Дэлгэрэнгүй мэдээллийг: <https://unstats.un.org/edge/publications/docs/Results%20of%20Pilot%20Survey%20in%20Mongolia.pdf>.

ХӨРСНИЙ ДОРОЙТОЛ, УСНЫ ХОМСДОЛ УЛАМ БҮР МЭДРЭГДЭЖ, ХҮН АМЫН АМЬЖИРГААНД НӨЛӨӨЛӨХ БОЛЛОО.

Уур амьсгалын өөрчлөлт, бохирдол нэмэгдэж, биологийн олон янз байдал алдагдахын зэрэгцээ газар тариалан, мал аж ахуй эрхэлж буй бэлчээр, газар нутаг улам бүр доройтож байгаа нь анзаарагдаж эхэллээ (Зураг 26). Хөрсний доройтлын гол үзүүлэлтүүдэд үржил шим буурах, хөрсний хүчиллэг, шүлтлэг байдалд өөрчлөлт орох, элэгдэлд өртөмтгий байдал, хортон шавжид өртөмтгий болох, органик бодисын алдагдал, биологийн олон янз байдлын ерөнхий алдагдал зэрэг хамаарна. Эдгээр нь газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний гарц, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний эрүүл мэнд, чанарт мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болзошгүй. Монголд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөө аж ахуйн салбарт урт хугацаанд ажилласан, мэргэшсэн байдаг тул хөрсний үржил шим буурч, элэгдэл, усны хомсдол, хөрсний доройтол үүсэж байгааг илүү сайн анзаардаг байна (Зураг 27). Хэдийгээр зөрүү тийм их биш боловч судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 17, эрэгтэйчүүдийн 36 хувь нь хөрсний доройтол нэмэгдэж байгааг анзаарч мэдсэн байдаг. Зураг 24-т үзүүлсэн тоон мэдээлэл ч хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн зарцуулж буй цаг, ачаалал хэрхэн нэмэгдэж буйг харуулж байна. Хөрсний доройтлыг бууруулахын тулд бордоо ашиглахыг зөв гэж олонх тариаланчид үздэг ч тухайн хөрсний шинж чанарт нийцүүлэн, зохих ёсоор ашиглаагүй нөхцөлд хөрсийг улам гэмтээж, ойр орчмын усны зам, чанарт нөлөөлөхөөс гадна биологийн олон янз байдал алдагдахад хүргэдэг байна.

Зураг 26: Хөдөө аж ахуйн зорилгоор эзэмшиж, ашиглаж буй газар нь хөрсний доройтолд орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр, хөрсний доройтлын төрлөөр (хувь)



Тайлбар: Энэ ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй (p<0.05).

Зураг 27: ХАА-н зорилгоор эзэмшиж, ашиглаж буй газар нь хөрсний доройтолд орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр, (хувь)



Тайлбар: Энэ ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$)

IV БҮЛЭГ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ДОРОЙТОЛ, ШИЙДВЭР ГАРГАЛТ

ЭРЭГТЭЙ МАЛЧИД ЭМЭГТЭЙЧҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ГАЗАР ТАРИАЛАН, МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛСНИЙ УЛМААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ, УЛ МӨРИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ТҮЛХҮҮ ХЭРЭГЖҮҮЛДЭГ.

Байгаль хамгаалал, хөрсний доройтлыг бууруулахад эрэгтэй, эмэгтэй иргэдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг танин мэдэхэд иргэдийн байгаль орчинтойгоо харьцаж буй харилцааны онцлог, давтамж, эрчим зэргийг сайн ойлгох нь чухал юм. Байгалийн нөөцийн тэгш хүртээмж, шийдвэр гаргах эрх мэдэл, өмч хөрөнгө эзэмшил дэх жендэрийн ялгаатай байдал нь байгаль хамгаалах, хүрээлэн буй орчин, байгалийн баялгийн доройтлыг сааруулахад чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хандлага, төлөвийг тодорхойлдог.

Синтетик пестицид, бордоо, өсөлт дэмжигч бодисыг ашиглах нь биологийн олон янз байдал алдагдах, бохирдол, хүний мэдрэлийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байдаг. Иймд эдгээр бодистой харьцахдаа маш болгоомжтой байж, аливаа эрсдэлийг бууруулахад анхаарах нь чухал боловч иргэд зохих дүрэм, зааврын дагуу ашигладаггүйгээс гадна энэ хандлага эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд өөр өөр байдаг (Зураг 28). Монголд газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн ихэнх нь эдгээр бодисыг хэрэглэдэггүй ч эдгээр бодисыг ашигласан нөхцөлд 4 эрэгтэй малчин, тариаланч тутмын зөвхөн нэг нь зааврыг дагаж мөрдөх, холбогдох дүрэм, журмыг баримтлах, санал болгож буй тунгаас хэтрүүлэхгүй байх, шим тэжээлийн органик эх үүсвэрийг ашиглах, буурцагт ургамлыг нөмрөг болгон ашиглах, усны урсцын зурвасыг хамгаалах гэх мэт илүү мэдээлэлтэй арга хэмжээ авдаг байна.

Зураг 28: ХАА-н зорилгоор ашиглаж, эзэмшиж буй газартаа бордоо ашигласнаас үүдэн гарах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авсан хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)



Тайлбар: Эдгээр тоо нь бордоо ашигласнаас үүдэн гарах эрсдэлийг бууруулах арга хэмжээний нэгтгэлийг харуулж байгаа юм: Үүнд: 1) холбогдох бүх протоколыг дагах, жижиглэн худалдаа, орон нутгийн дүрэм, журам г.м; 2) Шим тэжээлийн органик эх үүсвэр ашиглах (бууц, бордооны үлдэгдэл), 3 Буурцагт ургамлыг бүрхэвч, эсвэл олон таримал бэлчээрийн системийн бүрэлдэхүүн болгож ашиглах; 4) Бордооны тун, давтамжийг сонгохдоо хөрсний төрөл, уур амьсгалыг харгалзан үзэх; 5) Усны урсгалын дагуу буфер туузыг ашиглах. Энэ ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Цаашилбал, газар тариалан, малын бэлчээрийн байгаль орчны үл мөрийг бууруулах бусад арга хэмжээ, тухайлбал пестицидийн агууламжийг хязгаарлах, холимог тариалалт хийх, бэлчээр сэлгэлтийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг эрэгтэй малчид түлхүү хэрэгжүүлдэг байна. Ойролцоогоор дөрвөн хүн тутмын нэг нь ХАА эсвэл мал аж ахуй эрхэлдэг бөгөөд дээр дурдсан арга хэмжээнээс наанадаж 1 арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг ажээ. Байгаль хамгаалахад чухал үүрэгтэй эдгээр дадал, хэвшлийг цаашид өргөн хүрээнд хэвшүүлэх тогтвортой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сурталчлах нь чухал ач холбогдолтой юм. (Зураг 29).

Зураг 29: ХАА-н зорилгоор ашиглаж, эзэмшиж буй газартаа малын бэлчээрийн байгаль орчны үл мөрийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн хүн амын эзлэх хувь (хүйс)



Тайлбар: Эдгээр тоо нь бордоотой холбоотой аливаа эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээний нийлбэрийг илэрхийлнэ. Үүнд: 1) Пестицидийн шошгын зааврыг дагах; 2) Тариалан хоорондын хугацааг тохируулах; 3) Ургац авах талбай хоорондын зай; 4) Тариалангийн талбайд ротаци хийх 5) Холимог тариалангийн арга ашиглах, 6) биологийн хортон шавжийн хяналт 7) Биопестицийн ашиглалт, 8) Мал, амьтны хортон шавжийг бууруулах зорилгоор бэлчээрийн ротацийн аргыг ашиглах; 9) Шавжийн дайралтад өртсөн ургамлыг системтэйгээр зайлуулах; 10) Ашигласны дараа шүршүүрийн тоног төхөөрөмжийг арчиж, цэвэрлэх 11) Тэсвэржилт үүсгэхгүйн тулд улиралд 2-с дээш удаа пестицид ашиглахгүй байх (холимог пестицид). Энэ ангилалд эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй)


МОНГОЛ УЛСАД МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН МЕНЕЖМЕНТ ТОГТВОРТОЙ БАЙГАА НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ЭЕРЭГ ДОХИО ЮМ.

Монгол Улсын нийт өрхийн 40 орчим хувьд нь эрэгтэйчүүд нь мал маллах болон бусад тэжээвэр амьтан маллах ажлыг хариуцдаг бол эмэгтэйчүүдийн хувьд энэ тоо дөнгөж 10 хувьтай байна (Зураг 30). Нийт өрхийн 15 хувьд энэ ажлыг гэрийн эрэгтэй, эмэгтэй гишүүд хамтран гүйцэтгэдэг гэж хариулжээ. Мал аж ахуйн салбарын менежмент, түүнтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг татан оролцуулах нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй малчид хамтран хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой.

Монгол орны тухайд байгаль орчныг хамгаалах замаар мал аж ахуй эрхлэх гэдэгт мал бэлчих талбайг хаших, бэлчээрийн даац хэтрүүлэхээс сэргийлж сэлгэн нутаглах зэрэг арга, дадал түгээмэл байдаг. Нийт мал аж ахуй эрхэлж буй эмэгтэйчүүдийн 41, эрэгтэйчүүдийн 44 хувь нь малын хортон шавжийн тоог бууруулах, бэлчээрийн даац хэтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээр сэлгэх зэрэг арга хэмжээ авдаг гэсэн тооцоо бий. Эрэгтэйчүүдээс илүү эмэгтэй малчид малынхаа ашиг шимийг органик гэж баталгаажуулахад чиглэсэн арга, дадлыг түлхүү хэрэглэдэг. Тэдний мал маллах арга ухаан менежмент нь байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн эсэхийг тодруулахад эмэгтэйчүүдийн 74, эрэгтэйчүүдийн 71 хувь нь тийм гэж хариулжээ (Зураг 31). Энэ нь антибиотик, өсөлтийн даавар эсвэл бусад төрлийн тэжээлийн орц (эмэгтэйчүүдийн 52, эрэгтэйчүүдийн 56 хувь) хэрэглэхээс татгалзсантай холбоотой байж болох юм.

Монгол Улсад органик мал аж ахуй өргөн тархсан бөгөөд таван фермер тутмын дөрөв нь органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Эмэгтэй малчид аливаа даавар эсвэл антибиотик хэрэглэхээс татгалзах гэх мэт органик баталгаажуулалтын протоколыг эрчүүдээс сайн дагаж мөрддөг; Харин эрэгтэй малчид малаа сүүдэр газар бэлчээх, мал хэвтэх хангалттай зай талбай, цэвэр ундны ус, малын өтөг, бууц хураах, бэлтгэх газар, нар сайн тусдаг, цэвэр, хуурай малын хэвтэр бэлтгэх зэрэгт түлхүү анхаарлаа хандуулдаг байна. Малдаа органик тэжээл өгөх дадал эмэгтэй, эрэгтэй малчдын дунд бараг ижил байгаа бол тариаланчдын 80 орчим хувь нь малын тэжээлийн хэрэгцээг хангахад шаардлагатай эрдэс бодис, витаминаас бусад гений өөрчлөлттэй үр тариа болон бусад органик бус бүтээгдэхүүн хэрэглэхээс зайлсхийдэг (Зураг 32). Монгол оронд мал аж ахуй эрхлэх дээрх туршлага түгээмэл байгаа нь тогтвортой байдлыг бүхэлд нь хангах нааштай үзүүлэлт мөн бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчны доройтлыг хязгаарлахад чухал ач холбогдолтой юм.

Зураг 30: Дангаар болон хамтран эзэмшдэг малаа ихэвчлэн малладаг хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)




Тайлбар: "Өрх дэх эмэгтэй гишүүн" гэдэг нь судалгаа авах үед тухайн үйл ажиллагааг голчлон хариуцдаг гэж хариулсан эмэгтэй өрхийн гишүүнийг илэрхийлэхээс гадна өрхийн эмэгтэй гишүүн тухайн үйл ажиллагааг голчлон хариуцдаг гэж мэдээлсэн аль ч хүйсийн иргэний мэдээлэл мөн багтсан болно. "Өрх дэх эрэгтэй гишүүн" гэдэг нь судалгаа авах үед тухайн үйл ажиллагааг голчлон хариуцдаг гэж хариулсан эрэгтэй өрхийн гишүүнийг илэрхийлэхээс гадна өрхийн эрэгтэй гишүүн тухайн үйл ажиллагааг голчлон хариуцдаг гэж мэдээлсэн аль ч хүйсийн иргэний мэдээлэл мөн багтсан болно. "эрэгтэй, эмэгтэй хамтдаа" гэдэг нь тухайн үйл ажиллагааг өрхийн эрэгтэй, эмэгтэй гишүүд ижил тэгш хуваан гүйцэтгэдэг гэсэн утгатай.

Зураг 31: Байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалж буй мал аж ахуй эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр (хувь)



Тайлбар: Энэ хэсэгт эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).

Зураг 32: Мал, амьтны аж ахуй эрхлэх арга дадал нь байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн хүн амын эзлэх хувь, арга, дадлын төрөл, хүйсээр (хувь)



Тайлбар: Энэ хэсэгт эрэгтэй, эмэгтэй иргэдийн хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).


ӨРХИЙН ТҮВШНИЙ АЛИВАА АРГА, ТУРШЛАГА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЭСВЭЛ ДОРОЙТУУЛАХАД ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД НӨЛӨӨЛДӨГ.

Эрчим хүчний олон эх үүсвэрийн ашиглалт, хоол хийх, орон байраа халаахад шаардагдах түлш, эрчим хүч нь байгаль орчны доройтолд янз бүрийн түвшинд нөлөөлдөг. Монгол улс нийт хүн амаа цахилгаанаар бүрэн хангаж чадсан ч сэргээгдэх бус эрчим хүчний эх үүсвэр ашиглан цахилгааны хэрэгцээгээ хангадаг билээ. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлагийн (IRENA) мэдээлснээр нийт эрчим хүчний хангамжийн 81 хувь нь нүүрс, 16 хувь нь газрын тос, үлдсэн 2 хувь нь сэргээгдэх эрчим хүчнээс бүрддэг.²¹ Иймээс өрх, гэрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нь байгаль орчны доройтолд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Арван өрхийн гурав нь (29 хувь) хоол хийхдээ хүний эрүүл мэндэд аюултай бензин, керосин, нүүрс, мод, сүрэл болон бусад хатуу, бохир түлш хэрэглэдэг. Монгол улсын нийт өрхийн 90 хувьд нь эмэгтэйчүүд хоол хийх ажил хариуцдаг ба хортой түлш хэрэглэх үед дотоод орчны агаарын бохирдолд эмэгтэйчүүд илүү өртдөг байна. Хоол хийхдээ цэвэр түлш хэрэглэдэг айл өрхийн 90 хувь, хортой түлш хэрэглэдэг айллуудын 87 хувь нь өрх гэрийн хоолыг эмэгтэйчүүд хамгийн их хийдэг гэсэн судалгаа байдаг (Зураг 33).

Цахилгаан эсвэл хий ашиглан хоол хүнсээ болгох боломжгүй нөхцөлд ихэнх өрх түлээ, нүүрсээ өөрсдөө цуглуулж, хоол ундаа хийдэг. Зураг 34-т хариулсны дагуу хоол хийхэд шаардагдах түлш цуглуулах ажлыг эрэгтэйчүүд түлхүү хийдэг (эрэгтэйчүүд 64 хувь, эмэгтэйчүүд 36 хувь). Мод, түлээ цуглуулж ашигладаг эдгээр иргэдийн хувьд ойн тогтвортой менежментийн арга барилыг ашиглах нь экосистемийн үйлдвэрлэл, ойн эрүүл мэндийг хамгаалахад нэн чухал юм.

Зураг 33: Охид, эмэгтэйчүүд, эсвэл эрэгтэйчүүд, хөвгүүд нь хоолоо хийдэг өрхийн эзлэх хувь, ашиглаж буй түлшний төрлөөр (хувь)



21 ОУСЭХА, Эрчим хүчний зураглал – Монгол Улс. Дэлгэрэнгүйг: https://www.irena.org/-/media/Files/IRENA/Agency/Statistics/Statistical_Profiles/Asia/Mongolia_Asia_RE_SP.pdf?rev=043f5c4c85054e179be1ae1b397e5972.

Зураг 34: Өрхийн хэрэглээний мод, түлээгээ бэлтгэх ажил хариуцсан бүлгийн эзлэх хувь, хүйсээр (хувь)




МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТАЛААС ИЛҮҮ ХУВЬ НЬ УНДНЫ УСАА ТОГТМОЛ ЗӨӨДӨГ. ТЭДНИЙ ЭНЭ ДАДАЛ, ТУРШЛАГА БАЙГАЛЬ ХАМГААЛАХАД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ.

Монгол улсын нийт өрхийн 63 хувь нь ундны цэвэр ус түгээх шугам хоолойгүй байшин, газар, хашаанд амьдардаг. Эдгээр өрхийн хувьд ундны усаа зөөн хэрэглэх нь тогтсон үйл ажиллагаа бөгөөд ихэнх тохиолдолд гэр бүлийн эрэгтэй гишүүний хийх ажил байдаг. Гэртээ цэвэр усны эх үүсвэргүй 5 айл өрхийн 3-с дээш өрхөд ус зөөх ажлыг эрэгтэй гишүүн хариуцдаг. Үүнээс гадна усны эх үүсвэр хол байх тусам эрэгтэйчүүд ус зөөх магадлал нэмэгддэг. Энэ нь их хүч шаарддаг ажил бөгөөд биеийн ерөнхий эрүүл мэндийг улам дордуулдаг (Зураг 35). Орчны бохирдол, урьдчилан таамаглах аргагүй хур тунадасны шинж байдал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт зэргээс шалтгаалан усны чанар, хүртээмж муудаж байгаа тул цэвэр ус авахад тулгарах бэрхшээл, хугацаа улам бүр нэмэгдэх магадлалтай. Хол газраас ус зөөх боломжгүй иргэдийн хувьд хоол хийх, цэвэрлэгээ хийхэд хангалттай цэвэр, аюулгүй ундны усны эх үүсвэрийг ойрын зайнд хайх, усыг цэвэршүүлэхэд зарцуулах цаг хугацаа нэмэгдэх магадлалтай бөгөөд энэ нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн хийдэг ажил юм. Устай холбоотой бүх үйл ажиллагаанд шаардагдах хугацаа уртассанаар ачаалал нэмэгдэж энэ нь цалинтай хөдөлмөр эрхлэгч иргэдийн хөдөлмөр эрхлэлт, чөлөөт цагаа өнгөрөөхөд сөргөөр нөлөөлнө.

Түүнчлэн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ус зөөх, ашиглах хандлага нь цэвэр усны чанар, хүртээмжид нөлөөлж болзошгүй. Хэдийгээр Монгол Улсад цэвэр усны татан авалтын 36 хувь нь үйлдвэрийнх²² боловч айл өрхүүд тэр дундаа газар тариалан эрхэлдэг өрхүүд цэвэр усны томоохон хэрэглэгч байдаг. Хүн амын дийлэнх нь мал сүргээ өсгөж байгаа тул хүмүүсийн малаа бэлчээх газар, эсвэл малын тэжээл бэлтгэх, өтөг бууц цуглуулах зэрэгт ашиглах усны эх үүсвэр нь цэвэр усны чанар, хүртээмжид ихээхэн нөлөөлдөг. Усны нөөцийн тогтвортой менежментийг боломжит түвшинд хүртэл дэмжихийн тулд олборлолтыг хязгаарлах, түүнчлэн усны эх үүсвэрийг хатуу, шингэн, химийн болон органик бодисоор бохирдуулсны торгууль ногдуулах г.м хатуу журам тогтоож, хэрэгжүүлэх ёстой. Усны зам дагуу олборлолт хийх, бохир ус ихээр үйлдвэрлэж буй иргэдийн хувьд мэдээллийн кампанит ажил явуулах нь олборлолт хийх, хөрс нурах, хог хаягдал хаях зэрэг үйл ажиллагааг хязгаарлахад чиглэсэн хуулийн хэрэгжилтийг дэмжиж болох юм.

22 Дэлхийн банк, 2024. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн мэдээллийн бааз. Дэлгэрэнгүй мэдээллийг : <https://data.worldbank.org/indicator/ER.H2O.FWIN.ZS>.

Зураг 35: Өрхийн хэрэглээний үс зөөх ажил хариуцсан бүлгийн эзлэх хувь, усны эх үүсвэр хүртэлх зайгаар (хувь)




Тайлбар: “0–29 минут” гэсэн хэсэгт хүйс хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдав.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭМЭГТЭЙ, ЭРЭГТЭЙ ХҮН БҮРИЙН ХЭРЭГЦЭЭНД НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХИЙГ БАТАЛГААЖУУЛАХАД ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦЫН ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОО ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ.

Монгол улсын уур амьсгалын Үндэсний хороо нь Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан төрийн салбар хоорондын уялдаа холбоог ханган ажилладаг байгууллага юм. Тус бүтэц нь үндэсний хөгжлийн стратегийн хүрээнд уур амьсгалтай холбоотой арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй. Мөн түүнчлэн, тус хороо болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааг дэмжин ажилладаг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв гэж байгууллага бий. Дээр дурдсан засгийн газрын түвшний байгууллагуудаас гадна орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн байгууллага байдаг. Иймд судалгаанд оролцогчдоос уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагаврыг сааруулах, бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг эдгээр байгууллагад итгэж, хамтран ажилладаг эсэхийг лавлахад 3 хувь нь тийм гэж хариулжээ (Зураг 36). Уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны холбогдолтой аливаа шийдвэр гаргах үйл явцад иргэдийн өргөн оролцоог дэмжих нь сөрөг нөлөөг бууруулах, байгалийн нөөцийн менежментийн шийдвэрүүд орон нутгийн эрэгтэй, эмэгтэй иргэн бүрд ашиг тустай байхад чухал нөлөөтэй. Байгаль орчноос хамааралтай амьдардаг хүн ам ихтэй орны хувьд энэ нь дараагийн чухал алхам юм.

Зураг 36: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг арилгах, бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байгууллагад харьяалагддаг хүн амын эзлэх хувь, хүйсээр



Тайлбар: Энэ хэсэгт эрэгтэй, эмэгтэй иргэд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p < 0.05$).



NATIONAL
STATISTICS OFFICE
OF MONGOLIA

